

社会開発調査部報告書

No. 52

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМРЫН АЖИЛАГ АМНЫ  
АРЕГЭЛАГ ОЖИКА)  
МОНГОЛ УЛСЫН ДЭД БУТЦЫНН ХӨГЖЛИНН ЯАМ

МОНГОЛ УЛСАД УЕМОСНИЙ АЯМАЛСУУЧИЛАЛЫГ ХӨГЖУУЛӨХ  
МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ



ТӨГСГӨЛИЙН  
ИЛТГЭЛ

Хураангуй

1999 оны 7 дугаар сар

JICA LIBRARY



J 1151294 (4)

JICA  
115  
759  
SSF  
LIBRARY

ЦАДЕКО Ко., Лтд.,  
Нидмон Ко.эй Ко., Лтд.,

S	S	F
J	R	
99 - 101		



**ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ  
АГЕНТЛАГ (ЖАЙКА)  
МОНГОЛ УЛСЫН ДЭДБУТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

**МОНГОЛ УЛСАД УНДЭСНИЙ АЯЛАЛЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖУУЛЭХ**

**МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ**

**ТӨГСГӨЛИЙН  
ИЛТГЭЛ  
Хураангуй**

**1999 оны 7 дугаар сар**

**ПАДЕКО Ко., ЛтА.  
Ниппон Коэй Ко., ЛтА.**

**Шаардлагатай тохиолдолд валютыг хөрвүүлэхэд зориулав**  
**1999 оны 5 дугаар сарын валютын ханшийг үндэслэв.**

**1ам. доллар= 870 төгрөг**

**1ам. доллар=115 иен**



**1151294 {4}**



## Удирдтгал

Япон Улсын Засгийн газар Монгол Улсын Засгийн газрын хүсэлтийн дагуу "Монгол Улсад Үндэсний Аялал Жуулчлалыг Хөгжүүлэх Мастер Төлөвлөгөө"-г боловсруулахаар шийдвэрлэж судалгааны ажлыг хийж гүйцэтгүүлэхээр Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг (ЖАЙКА)-ийг томилсон юм.

ЖАЙКА нь ПАДЕКО Ко., Лтд болон Ниппон Козэй Ко., Лтд кампаниудаас бүрдсэн консорциумыг сонгож Юичиро Мотомурагаар удирдуулсан судалгааны багийг 1998 оны 3дугаар сараас 1999 оны 7дугаар сарын хооронд 3 дахин томилж явуулсан болно.

Тус баг нь Монголын Засгийн газрын албаны холбогдох хүмүүстэй уулзаж ярилцан газар дээр нь судалгааг явуулсан бөгөөд Японд буцаж ирсний дараа ч цаашдын судалгааны ажлаа үргэлжлүүлж энэхүү илтгэлийг боловсруулсан болно.

Тус илтгэл Монгол улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх, манай хоёр орны найрсаг харилцааг өргөжүүлэхэд хувь нэмэр оруулна гэж би найдаж байна.

Судалгааны багтай нягт хамтран ажиллаж дэмжлэг үзүүлсэн Монголын Засгийн газрын албаны хүмүүст гүн талархалаа илэрхийлэхийг би хүсч байна.

1999 оны 7 дугаар сар



Кимио Фужита  
Японы Олон Улсын Хамтын  
Ажиллагааны Агентлагын Захирал

Япон улс, Токио хот  
Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлагын  
Захирал  
Ноён Кимио Фүжита танаа

1999 оны 7дугаар  
сар

### Өргөн барих захидал

Хүндэт ноён Кимио Фүжита танаа

" Монгол Улсад үндэсний аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө"- ний төгсгөлийн илтгэлийг үүгээр албан ёсоор өргөн барьж байгаадаа бид баяртай байна.


Энэхүү илтгэл нь ПАДЕКО Ко., Лтд. болон Ниппон Козй Ко., Лтд кампаниудын хамтран зохион байгуулсан Судалгааны багийн хүчээр 1998 оны 3дугаар сараас 1999 оны 7дугаар сар хүртэлх хугацаанд Монгол улсад явуулсан судалгааны ажлын үр дүнг багтааж байгаа болно.

Энэ илтгэлийг боловсруулахад олон хүмүүсийн хүчин зүтгэл оролцсоныг бид зүй ёсоор тэмдэглэж байна. Юуны түрүүнд Судалгааны багт гүн туслалцаа үзүүлж хамтран ажилласан хүмүүс, тухайлбал судлагааны Монголын талын багийн гишүүд болон Монгол Улсын Дэд бүтцийн хөгжлийн яамны холбогдох ажилтнуудад гүнээ баярлан талархаж буйгаа илэрхийлж байна.

Мөн танай агентлагын болон ЖАЙКА- гийн Зөвлөх Хороо, Монгол Улс дахь Японы Элчин сайдын яамны албаны хүмүүст гүн талархал илэрхийлье.

Монгол Улсын нийгэм- эдийн засгийн цаашдын хөгжилд энэхүү илтгэл нь үр нөлөөтэй хувь нэмэр оруулаасай хэмээн бид хүсч байна.

Гүнээ хүндэтгэсэн



Юүичиро Мотомура

Монгол Улсад үндэсний аялал  
жуулчлалыг хөгжүүлэх мастер  
төлөвлөгөө боловсруулах  
Судалгааны Багийн удирдагч





**Монгол Улсад  
Үндэсний Аялал Жуулчлалыг Хөгжүүлэх  
Мастер Төлөвлөгөө  
Төгсгөлийн Илтгэл**

**Хураангуй**

**Агуулга**

Дүгнэлт, зөвлөмжүүд.....	ii
<b>1. Өмнөх үг.....</b>	<b>1</b>
<b>2. Монгол Улсын аялал жуулчлалын өнөөгийн байдал.....</b>	<b>2</b>
2.1 Аялал жуулчлалын эрэлт хэрэгцээ.....	2
2.2 Аялал жуулчлалын нөөц, материаллаг бааз.....	8
2.3 Аялал жуулчлал хариуцсан засгийн газрын байгууллагууд.....	8
<b>3. Үндэсний аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, стратеги.....</b>	<b>12</b>
3.1 Аялал жуулчлалыг хөгжүүлэх ерөнхий стратеги.....	12
3.2 Аялал жуулчлалын эрэлт хэрэгцээний төлөв.....	13
3.3 Бүс нутгийн хөгжлийн стратеги.....	16
3.4 Аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө.....	20
3.5 Систем/зохион байгуулалтыг хөгжүүлэх төлөвлөгөө.....	22
3.6 Дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөгөө.....	24
3.7 Хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө.....	25
3.8 Байгаль орчны менежмент болон аялал жуулчлалын хөгжил.....	26
3.9 Монгол Улсын эдийн засгийн хөгжилд аялал жуулчлалын оруулах хувь нэмэр.....	27
<b>4. Бүс нутгийн төлөвлөгөө.....</b>	<b>29</b>
4.1 Улаанбаатар хотын орчин.....	29
4.2 Хархорины бүс нутаг.....	33
4.3 Өмнөговийн бүс нутаг.....	38
<b>5. Тэргүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөрүүд.....</b>	<b>43</b>
5.1 Тэргүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдийн сонголт.....	43
5.2 Тэргүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөрүүд.....	45
<b>6. Тэргүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх     төлөвлөгөө.....</b>	<b>64</b>
6.1 Хэрэгжүүлэх хуваарь.....	64
6.2 Хэрэгжүүлэх байгууллага.....	65
6.3 Өртгийн тооцоо.....	66
<b>7. Үнэлгээ.....</b>	<b>67</b>
7.1 Эдийн засгийн үнэлгээ.....	67
7.2 Санхүүгийн үнэлгээ (хөнгөлөлттэй зээлийг эргүүлэн төлөх).....	68
7.3 Орчны анхдагч үнэлгээ.....	68
7.4 Орчны хүчин зүйлс.....	70



## 1. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖҮҮД

1) Монгол дахь олон улсын аялал жуулчлалыг Балба, Түвд, Өвөр Монголын нэгэн адил өвөрмэц сонирхлын аялал жуулчлалд хамааруулж болох юм. Хэдийгээр Монголд гадаадаас ирж буй жуулчдын тоо эрс өсч байгаа боловч тэр нь Балбын 12 хувьд ч (1996 оны байдлаар) хүрэхгүй байна. Үйлчилгээний түвшин, материаллаг баазын чанар дэлхийн түвшнээс доогуур байгаа тул дэлхийн аялал жуулчлалын зах зээл дээр өрсөлдөхийн тулд нэлээд арга хэмжээ авах шаардлагатай. Эдийн засгийн харилцан туслах зөвлөл (ЭЗХТЗ)-өөс гэнэт салж төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих амаргүй үйл явцыг хэрэгжүүлж байгаа нь Монголын эдийн засгийг сулруулсан учир эдийн засгийн өсөлтийг хангах экспортын үйлдвэрлэлийг бүрэлдүүлэх асуудал хурцаар тавигдаж байна. Гадаад валютын орлогыг нэмэгдүүлэхийн тулд түүнийг бүрдүүлж ирсэн хөдөө аж ахуй, уул уурхайн уламжлалт салбарын зэрэгцээгээр Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэхийн чухлыг Монголын бодлого тодорхойлогчид хүлээн зөвшөөрч байгаа болно.

2) Олон улсын түвшинд өрсөлдөх чадвар бүхий аялал жуулчлалыг Монголд хөгжүүлэх нөөц нь гэвэл (1) хүмүүс (нүүдэлчид) болон байгаль орчны (тал хээрийн) өвөрмэц зохилдолгоо (2) харьцангуй онгон байгаль (хээр тал, говь, ой хөвч, нуур, уулс) (3) өмнөх үеийн хүчирхэг улс гүрнээс үлдсэн түүх дурсгалын балгас, соёлын өв юм. Аялал жуулчлалын эдгээр нөөцийг хадгалан үлдээж, зохистой ашиглах замаар аялал жуулчлалыг Монголд хөгжүүлэх нь чухал.

3) Аялал жуулчлалын материаллаг бааз, үйлчилгээг сайжруулах, түүнчлэн удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох шаардлага тулгарч байна. Нэн тэргүүнд соёлын аялал жуулчлалыг хөгжүүлж дэмжих үүднээс энэ чиглэлийн газруудыг бэлтгэж тохижуулах, Улаанбаатар хотыг жуулчлалын гол төв болгон хөгжүүлэх, Хархорин, Өмнөговийн жуулчдын баазуудыг бэхжүүлэх, жуулчдыг мэдээллээр хангах, агаарын тээврийн үйлчилгээг сайжруулах, зочид буудлын тоог нэмэгдүүлж зэрэглэлийг дээшлүүлэх асуудлыг даруй шийдвэрлэх ёстой. Цаашилбал, байгалийн аялал жуулчлалын нөөцийг хамгаалах, түүх, соёлын дурсгалыг хадгалан хамгаалах арга хэмжээг аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын салшгүй хэсэг болгон авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс аялал жуулчлалын асуудал эрхэлсэн улсын болон хувийн хэвшлийн байгууллагуудыг бэхжүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх, сурталчилгаа, маркетингийн үр ашигтай механизмыг бий болгох, мөн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах хэм хэмжээ, зөвшөөрлийн системийг бүрдүүлвэл зохино.

4) Монголын бүс нутгийн хөгжлийн стратегийн талаар дэвшүүлж буй санал нь: Ойрын (2005 он хүртэлх) хугацаанд Улаанбаатар, Хархорин, Өмнөговь дахь аялал жуулчлалын төвийг бэхжүүлж Хөвсгөл, Хэнтий, Өлгий орчимд өвөрмэц сонирхлын жуулчлалыг хөгжүүлэх

замаар Монголын аялал жуулчлалын үндэс суурийг бүрдүүлэх. Дунд болон урт хугацааны зорилт болгон одоогийн үндсэн 3 бүс нутгийг цаашид улам хөгжүүлэхийн зэрэгцээгээр Дорноговь, Ховд, түүнчлэн Дорнод, Баянхонгор, Алтай зэрэг бүс нутагт өвөрмөц сонирхлын аялал жуулчлалыг шинээр хөгжүүлэх асуудлыг дэвшүүлэх.

5) 2015 он хүртэлх хугацаанд дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг санал болгож байна. Үүнд:

#### **Соёлын жуулчлалыг дэмжин хөгжүүлэх**

Түүх, соёлын дурсгалт зүйлс Монголын нутаг дэвсгэрт элбэг бий. Гэхдээ 1 дүгээрт, эдгээрийн өнөөгийн байдал, түүхийн үнэ цэнийг тодорхойлох судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг хийх, 2 дугаарт, тэдгээрийг хадгалж хамгаалах арга хэмжээ авах, 3 дугаарт, тэдгээрийг тайлбарлан танилцуулсан самбар, дэлгэцийг байрлуулах, ойр орчинд нь амралтын болон бусад байгууламжийг барьж байгуулах шаардлагатай байна. Түүнчлэн, нүүдэлчдийн соёл, амьдрал ахуйг аялал жуулчлалын нөөц болгон ашиглахын тулд музей, сэдэвт хүрээлэн, төвийг барьж байгуулах хэрэгтэй. Аялал жуулчлалын салбарт нүүдэлчин малчдыг оролцуулах тогтолцоог бүрдүүлэхдээ тэдний ахуй амьдрал, соёлыг хамгаалах асуудлыг хамтруулан хэрэгжүүлэх нь чухал.

#### **Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж, сайжруулах**

Монголын аялал жуулчлалын агуулгыг баяжуулах үүднээс аялал жуулчлалын гол төв болох Улаанбаатар хотыг түшиглэн суурин газрын аялал жуулчлалыг хөгжүүлэх хэрэгтэй. Улаанбаатар хотод жуулчдын аялалын зам маршрут, үйлчилгээний төвүүдийг бий болгох, хотын ойр орчимд сэдэвт хүрээлэн шинээр барьж байгуулах нь зүйтэй. Монголын аялал жуулчлалын хүрээг тэлэхийн тулд агаарын бөмбөрцөг, загас агнуур зэрэг аялал спортын төрлийг хөгжүүлэх, жуулчдад зориулсан галт тэрэгний цуваа аялуулж болох юм.

#### **Аялал жуулчлалын салбарын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог бэхжүүлэх**

- Төв болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын түвшинд аялал жуулчлалын удирдлагыг бэхжүүлэх, аялал жуулчлал эрхлэх зөвшөөрөл, лиценз олгох системийг тогтоож боловсронгуй болгох, маркетинг сурталчилгааны ажлыг сайжруулах, тус салбарт хөрөнгө оруулах хөшүүрэг бий болгох
- Хувийн хэвшлийн байгууллагын үйлчилгээг сайжруулах
- Маркетинг сурталчилгааг өргөжүүлж хөгжүүлэх

#### **Хүний нөөцийг хөгжүүлэх**

Аялал жуулчлалын салбарт тусгай мэргэжлийн болон дээд мэргэжлийн боловсон хүчин, тухайлбал зочид буудал, зоогийн газрын менежер,

ажилтанг сургаж бэлтгэх шаардлагатай. Мөн дадлага туршлагатай хөтөч-орчуулагч, байгаль хамгаалагчдыг бэлтгэх хэрэгтэй.

### **Байгаль орчинг хамгаалах**

Унаган төрхөө хадгалсан Монголын байгаль нь жуулчдын сонирхлыг татах гол хүчин зүйлийн нэг тул түүнийг хамгаалах асуудлыг Монгол Улсад аялал жуулчлал хөгжүүлэх асуудлын хүрээнд хамтруулан шийдэх ёстой. Зэрлэг ан амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр, эко-жуулчлал (байгалийн чиглэлийн аялал жуулчлал) хөгжүүлэх хөтөлбөр, чулуужсан малтмалыг хамгаалах хөтөлбөр, шувуудын амьдралыг судлах танин мэдэхүйн хөтөлбөр, мэргэжлийн газарчид, байгаль хамгаалагчдыг сургаж бэлтгэх хөтөлбөр, хээр талын менежментийн хөтөлбөр зэргийг багтаасан Байгаль орчныг хамгаалах иж бүрэн хөтөлбөрийг боловсруулах шаардлагатай.

### **Дэд бүтэц, үйлчилгээг сайжруулах**

- Орон нутгийн нислэгийн чиглэл, тоог нэмэгдүүлэх, суудал захиалгын систем, аюулгүй байдлыг сайжруулах
- Олон улсын нислэг болон зочид буудлын үнийг хямдруулах замаар олон улсын жуулчлалын үнийг бууруулах
- Улаанбаатар- Хархорины хоорондох замыг сайжруулж тэмдэгжүүлэх, зогсоол амралтын газруудыг байгуулах, жуулчлалын бүс нутаг дахь замыг засч сайжруулах
- Гэр баазуудын холбоо харилцаа, эрчим хүчний хангамж (нарны болон салхины эрчим хүч ашиглах), хог хаягдлыг зайлуулах асуудлыг оновчтой шийдэх

### **Бусад арга хэмжээ**

- Аялал жуулчлалын улирлыг (5- 10 дугаар сар) уртасгах зорилгоор тусгай баяр наадам, фестиваль зохион байгуулах, түүнчлэн гадаадын жуулчдыг татах үүднээс үнийг хямдруулах
- Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, иргэдийн эрүүл мэндийг сайжруулах үүднээс шилжилтийн үед орхигдсон хөдөө орон нутгийн халуун рашааныг сэргээж сайжруулах

### **б) Тэргүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх**

Тэргүүлэх чиглэлийн дараахь хөтөлбөрийг 2005 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхээр тодорхойлов. Үүнд:

**Хөтөлбөрүүд:**

**1. Засаг, захиргааны байгууллагуудыг бэхжүүлэх**

А– 1 Аялал жуулчлалын үндэсний зөвлөлийг тогтмол ажиллуулах

А– 2 Аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар аялал жуулчлалын удирдлагыг бэхжүүлэх

А– 3 Аймгуудын засаг захиргааны байгууллагуудыг бэхжүүлэх

**2. Хүний нөөцийг хөгжүүлэх**

А– 4 Аялал жуулчлалын сургалтыг сайжруулах

А– 5 Байгаль хамгаалагчдын сургалт явуулах

**3. Эрх зүйн зохицуулалтыг сайжруулах**

А– 6 Аялал жуулчлалын салбар дахь хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих

А– 7 Газар ашиглалтад тавих хяналтын арга хэмжээнүүд

А– 8 Лицензийн журам

А– 9 Аюулгүй байдлыг хангах жишиг

**4. Хөгжлийн хөтөлбөрүүд:**

А– 10 Монголын соёлын өвийг хамгаалах хөтөлбөр

А– 11 Эртний түүх дурсгалт газруудыг олон нийтэд танилцуулж сурталчлах

А– 12 Олон улсын агаарын тээврийн үйлчилгээг сайжруулах

А– 13 Орон нутгийн агаарын тээврийн үйлчилгээг сайжруулах

А– 14 Төмөр замын үйлчилгээг чанаржуулах

А– 15 Нүүдэлчдийг хамруулах тогтолцоо

А– 16 Археологийн болон зэрлэг ан амьтан, ургамлын нөөцийн үндэсний зурагт каталог, газрын зураг

А– 17 Эко– жуулчлалын мэдээллийн материалыг бүрдүүлэх

А– 18 Хүрээлэн буй орчны менежментийн нэгдсэн судалгаа

А– 19 Хилийн чанад дахь маркетинг

А– 20 Улаанбаатар хотын зочид буудлуудыг хөгжүүлэх ерөнхий чиглэл

А– 21 Бүс нутгуудаар гэр бааз хөгжүүлэх ерөнхий чиглэл

А– 22 Улаанбаатар хотын автобусны үйлчилгээний тухай гарын авлага– танилцуулга

А– 23 Автобус болон үзвэрийн газаруудад хэрэглэхэд тохиромжтой нэгдсэн тасалбар нэвтрүүлэх



## Улсын өмчийн хүрээний төслүүд

1. Соёлын аялал жуулчлалыг өргөжүүлэх
  - Б-1 Богд хааны музейг засч сайжруулах
  - Б-2 Монголын соёлын хүрээлэн
  - Б-3 Эрдэнэзуугийн ойр орчмыг тохижуулах
  - Б-4 Хархорины Зочдыг хүлээн авах төв
2. Улаанбаатар хотыг жуулчлалын гол төв болгон хөгжүүлэх
  - Б-5 Улаанбаатарт аялал жуулчлалын байнгын зам маршрут тогтоож хөгжүүлэх
  - Б-6 Улаанбаатарт жуулчдад зориулсан гудамж талбай байгуулах
  - Б-7 Улаанбаатарт бэлэг дурсгалын зүйлс болон гар урлалын бүтээгдэхүүний төв байгуулах
3. Байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх
  - Б-8 Тэрэлжийн Зочдыг хүлээн авах төв
  - Б-9 Говь дахь Зочдыг хүлээн авах төв
  - Б-10 Шувууд ажиглах газрыг бэлдэж байгуулах
4. Бусад хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүд
  - Б-11 Хархорин чиглэлийн жуулчдын зам
  - Б-12 Улаанбаатар– Хархорины төв автозамыг тэмдэгжүүлэх
  - Б-13 Халуун рашаан, сувиллын газруудыг засч сайжруулах
  - Б-14 Аялал жуулчлалын хувийн секторт зээл олгох тогтолцоо

## Хувийн хэвшлийн төслүүд

- В-1 Улаанбаатар– Хархорин төв автозамын дагуу алжаал тайлах амралтын газрууд байгуулах
- В-2 Гэр баазуудын нөхцөл ,материаллаг баазыг сайжруулах
- В-3 Өмнөговийн онгоцны буудлын зурвасыг сайжруулах
- В-4 Спортын идэвхтэй амралтыг өргөжүүлэх
- В-5 Морьдын хүрээлэн

## Шаардлагатай хөрөнгө

Эдгээр тэргүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд дараахь хөрөнгө шаардлагатай:

Хөтөлбөрүүд	13.2 сая ам. доллар
Улсын төсвөөс санхүүжих төслүүд	19.2 сая ам.доллар
Хувийн хэвшлийн төслүүд	4.7 сая ам. доллар
Бүгд	37.1 сая ам. доллар

7) Тэргүүлэх чиглэлийн хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэхийн үр ашиг



Тэргүүлэх чиглэлийн хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлснээр жилд гадаад орнуудаас ирэх жуулчдын тоо 2005 онд 75 000, 2015 онд 210 000 хүртэл нэмэгдэх тооцоотой байна. 2015 онд аялал жуулчлалын салбарын гадаад валютын жилийн орлого 232 сая ам. долларт хүрэх боломжтой бөгөөд бусад дагалдах үр дагаврыг оролцуулан тооцвол эдийн засгийн өгөөжийн дотоод илтгүүр 31.1 хувь болж Монгол дахь хөрөнгийн дагавар өртгөөс үлэмж давж байна.

Гэхдээ тэргүүлэх чиглэлийн хөтөлбөр, төслүүдийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болох олон улсын нислэгийн үнэ, маршрутыг үл сайжруулбаас дээрх эдийн засгийн өгөөжийн дотоод илтгүүр 18 хувь хүртэл буурах юм.

Улсын төсвөөс санхүүжих төслүүдэд шаардлагатай 39 сая ам. долларыг (үнийн нөлөөллийг тусгаснаар) гадаадын хөнгөлөлттэй зээлээр бүрэн санхүүжүүлсэн тохиолдолд уг зээлийг гадаадын жуулчдаас зочид буудлынхаа үнэд төлсөн төлбөрт 6.29 хувийн татвар ногдуулах замаар эргүүлэн төлөх бололцоотой.

8) Тэргүүлэх чиглэлийн хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх талаар

### **Санхүүгийн эх үүсвэр**

Монголын Засгийн газар ойрын хугацаанд төсөв санхүүгийн бэрхшээлтэй байх төлөвтэй. Иймд гадаадаас буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл болон техникийн тусламж авах талаар ажиллах нь зүйтэй болов уу. Дээр дурдсанаар, улсын төсвөөс санхүүжүүлэх төслүүдэд гадаадаас авах зээл тусламжийг гадаадын жуулчдаас олох валютын орлогоос эргүүлэн төлөх боломжтой учир улсын төсөв санхүүд төдийлэн дарамт үзүүлэхгүй.

### **Хэрэгжүүлэх байгууллагууд**

Аялал Жуулчлалын Үндэсний Төвийг аль болох хурдан хугацаанд ажилд нь оруулж Аялал Жуулчлалын Үндэсний Зөвлөлийн удирдлагын дор төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хариуцуулах нь зүйтэй болохыг зөвлөж байна.


### **Хийж гүйцэтгэх ажлууд**

Гадаадын хандивлагч орнуудаас тусламж дэмжлэг авах асуудлыг шийдвэрлэх талаар засгийн газрын холбогдох байгууллагууд харилцан тохиролцож саналаа нэгтгэх шаардлагатай. Энэ ажлыг Аялал Жуулчлалын Газар болон Аялал Жуулчлалын Үндэсний Төв удирдан зохион байгуулж засгийн газрын байгууллагуудын хооронд зохицуулалт хийх, хандивлагч орнуудаас хүсэх тусламжийн санал боловсруулах, түүнчлэн байгаль орчны нөлөөллийг судалгааг хийх зэрэг ажлыг гүйцэтгэсэн байх нь чухал.

Тэргүүлэх чиглэлийн хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх хугацааны талаар дор дурдсан зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

1999/2000	Засгийн газрын шугамаар хандивлагч орнуудаас тусламж хүсэх
2000/2001	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд төслүүдийг боловсруулах
2001/2002	Төслүүдийг нарийвчилан боловсруулах, барилгын ажлыг эхлүүлэх
2003– 2005	Төслүүдийн барилгын ажлыг гүйцэтгэж дуусгах





## 1. ӨМНӨХ ҮГ

### Оршил

Япон Улсын Засгийн газар Монгол Улсын Засгийн газрын хүсэлтийн дагуу "Монгол Улсад Үндэсний Аялал Жуулчлалыг хөгжүүлэх Мастер Төлөвлөгөө"-г (цаашид "Судалгаа" гэж нэрлэх) боловсруулахаар шийдвэрлэсэн болно.

Албан ёсны техникийн хамтын ажиллагааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үүргийг хүлээдэг Японы Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (цаашид ЖАЙКА гэж нэрлэх) нь ПАДЕКО болон Ниппон Козэй компаниудыг Японы талын судалгааны багаар (цаашид "Судалгааны баг" гэж нэрлэнэ) томилсон юм.

Судалгааг Монгол болон Японд жил гаруй хугацаанд хийж гүйцэтгэв. Энэхүү "Төгсгөлийн илтгэл" нь ерөнхий төлөвлөгөөний төсөл болон ажлын төлөвлөгөөнөөс бүрдэж буй бөгөөд 1999 оны 3 дугаар сарын эцэс хүртэлх хугацааны судалгааны ажлын үр дүнг багтааж байгаа юм. Энэхүү илтгэлд тусгагдсан бүх үнэлгээ, санал, дүгнэлт нь урьдчилсан шинж чанартай тул цаашид өөрчлөгдөж болох талтай.

Монгол Улсын Засгийн газраас Судалгааны багтай хамтран ажиллах агентлагаар Дэд бүтцийн хөгжлийн яамыг томилсон бөгөөд тус яам нь Судалгааг саадгүй хэрэгжүүлэхийн тулд засгийн газрын болон засгийн газрын бус холбогдох байгууллагуудтай үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, үүний дотор Удирдлагын зөвлөлийг байгуулж ажиллуулах үүргийг хүлээсэн.

Мөн ЖАЙКА нь Японд хийх Судалгаанд хяналт тавих зорилгоор Зөвлөх Хороог томилж ажиллуулсан болно. Судалгааны баг, Удирдлагын зөвлөл болон Япон дахь Зөвлөх Хорооны гишүүдийн нэрсийн жагсаалтыг илтгэлийн төгсгөлд хавсаргав.

### Илтгэлийн бүтэц

Энэхүү илтгэл нь "Монгол Улсад Үндэсний Аялал Жуулчлалыг хөгжүүлэх Мастер Төлөвлөгөө"-ний Төгсгөлийн Илтгэлийн Хураангуй болно.

Төгсгөлийн Илтгэл нь дор дурдсан 5 бүлгээс бүрдэнэ. Үүнд:

1. Хураангуй
2. 1 дүгээр бүлэг Өнөөгийн байдал
3. 2 дугаар бүлэг Мастер төлөвлөгөө
4. 3 дугаар бүлэг Ажлын төлөвлөгөө
5. 4 дүгээр бүлэг Хавсралтууд

## 2. МОНГОЛ УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### 2.1 Аялал жуулчлалын эрэлт, хэрэгцээ

#### 1) Монгол дахь аялал жуулчлалын эрэлт, хэрэгцээний өнөөгийн байдал

Монгол Улсад 1997 онд 80 орчим мянган гадаадын иргэд зорчин иржээ. Тэдгээрээс 23 мянган хүн аялал жуулчлалын зорилгоор, 60 мянган хүн бизнесийн зорилгоор, үүний дотор БНХАУ-аас 33 мянган хүн, ОХУ-аас 9 мянган хүн тус тус хүрэлцэн ирсэн байна. Японоос ирсэн жуулчдын тоо 1997 онд 11 мянгад хүрсэн нь 1990 онтой харьцуулбал 30 хувиар (1997 онд 1996 оноос 17 хувиар) нэмэгджээ.

Улсын хилээр нэвтрэн орсон гадаадын иргэд

Орон бүс нутаг	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997
Америк тив	900	2034	2412	3217	4110	4322	3834	5019
Япон	1700	3900	5300	5600	5725	8976	9504	11077
Хятад	0	0	0	35100	42043	47721	30478	32531
Өмнөд Солонгос	0	0	0	700	911	2561	3537	3294
Зүүн Ази/Номхон далай	100	23	49	750	1810	1857	1214	2654
Өмнөд Ази, Африк Болон Ойрхи Дорнод	0	0	0	200	616	810	464	585
ОХУ	124000	76100	88000	73800	57171	28390	8502	8708
Төв/Зүүн Европ	8800	3900	1300	610	1036	1441	1755	2538
Герман	1200	1700	2100	2200	2560	3502	2782	3339
Бусад Европын Орнууд	700	1500	1200	3300	8019	8854	8761	11238
<b>Бүгд</b>	<b>137400</b>	<b>89157</b>	<b>100361</b>	<b>125477</b>	<b>124001</b>	<b>108434</b>	<b>70831</b>	<b>80983</b>

Эх сурвалж: Батлан хамгаалах яамны Хилийн Цэргийг Удирдах газар

2) Жуулчдын дунд явуулсан санал асуулгын дүн

1997 онд Япон болон бусад орноос ирсэн зочдыг Улаанбаатарын нисэх онгоцны буудал, Улаанбаатарын зочид буудал болон гэр баазуудад байхад нь уулзаж санал асуулга явуулан бие даасан 2 судалгаа хийсний үр дүнг нэгтгэн үзүүлбээс.

Японоос	Зүүн Азиас	Европоос (Хятадыг оруулан)	Бүгд
1416	340	1275	3031

Японоос ирсэн жуулчдын дунд явуулсан санал асуулгын дүнг харуулбал

<b>Судалгаа явуулсан газрууд</b>			
Улаанбаатарын нисэх онгоцны буудал		739 (52.2 хувь)	
Улаанбаатарын зочид буудлууд		382 (27.0 хувь)	
Жуулчдын гэр баазууд		295 (20.8 хувь)	
<b>Бүгд</b>		<b>1416 (100 хувь)</b>	
<b>Хүйс</b>	<b>Эрэгтэй</b>	<b>52.4 хувь</b>	<b>Эмэгтэй 47.6 хувь</b>
<b>Нас</b>	<b>60 наснаас дээш</b>	<b>24.5 хувь</b>	
	50/59	23.8 хувь	
	40/49	14.1 хувь	
	30/39	15.6 хувь	
	20/29	20.9 хувь	
	19 наснаас доош	0.9 хувь	
<b>Гадаадад жуулчилсан байдал</b>	<b>10/түүнээс дээш</b>	<b>44.2 хувь</b>	
	5/9 удаа	27.2 хувь	
	2/4 удаа	23.4 хувь	
	анх удаа	5.2 хувь	
<b>Групп жуулчлал, групп бус жуулчлал</b>			
<b>Групп</b>	<b>58.2 хувь</b>	<b>Групп бус</b>	<b>41.8 хувь</b>
<b>Урьд өмнө Монголд ирж байсан</b>	<b>тоо анх удаа</b>	<b>79.0 хувь</b>	
	2 дахь удаа	11.4 хувь	
	3 дахь болон түүнээс дээш	9.6 хувь	
<b>Дахин ирэх , ирэхгүй</b>	<b>ирнэ</b>	<b>86.5 хувь</b>	<b>ирэхгүй 13.5 хувь</b>

### 3) Монголын олон улсын аялал жуулчлалын зах зээл

#### (1) Олон улсын түвшин дэх өрсөлдөөн

##### Японы зах зээл

Монгол Улс нь Японоос хэдийгээр харьцангуй ойрхон орших (4/5 цаг нисч хүрнэ) боловч 2.1 дүгээр хүснэгтэд үзүүлснээр 8–9 өдрийн программ бүхий холын зайн чиглэлд хамаардаг. Энэ нь Монгол дахь аялал жуулчлалын маркетинг хийх суурь бааз бага хэмжээтэй, хязгаарлагдмал, өвөрмөц сонирхлын аялал жуулчлалыг голлосон, түүнчлэн ирэхэд хүндрэлтэй байгаатай холбоотой юм.

Олон улсын аялал жуулчлалын зах зээлийн хувьд авч үзвэл Японы жуулчдын аялдаг холын чиглэлүүд доорхи үндсэн 3 хэсэгт хуваагдаж байна.

Зах зээлийн хэмжээ	Чиглэлийн тодорхойлолт	Жишээ
1.Том	нийтийг хамарсан, ерөнхий сонирхол татах	БНХАУ, Америк Европ
2.Дунд зэргийн	холимог сонирхол бүхий	Хятадын Төв Ази Египет, Түрк, Энэтхэг
3. Жижиг хязгаарлагдмал	өвөрмөц сонирхлын жуулчлал/байнгын бус	Монгол, Балба, Төвд

Үүнээс үзэхэд Монгол нь хязгаарлагдмал жижиг зах зээл бүхий өвөрмөц сонирхлын аялал жуулчлалын нэг чиглэлд (3– т зааснаар) багтаж байна.

##### – Хятадын Өвөр Монгол

(Жуулчлалын томоохон зах зээл болох Хятад руу чиглэсэн жуулчлалын программуудын хавсралт маягаар зохион байгуулагдаж буй энэ чиглэлийн жуулчлал нь Монголтой шууд өрсөлдөх болж байна)

##### – Хятадын Төв Ази


( Торгон Замын зүүн хэсгийг хамрах учир дэлхийн хэмжээний сонирхол татахуйц маш их нөөцтэй чухал чиглэл )

##### – Төв Ази– Узбекистан, Киргиз


( Торгон замын баруун хэсгийг хамрах учир дэлхийн хэмжээний сонирхол татахуйц маш их нөөцтэй чухал чиглэл )



Японы аялал жуулчлалын зах зээл дээр Монголын эзэлж буй байр суурь



Японы жуулчид



МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ ЯОНЫ ОРОН УЛСЫН ХАМТЫН АЖИВАГААНЫ АГЕНТЛАГ (ЯАРКА)
МОНГОЛ УЛСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨӨЛӨГӨӨ
Хүснэгт 2.1 Японы аялал жуулчлалын зах зээл дээр Монголын эзэлж буй байр суурь
ПАДЕКО Ко., Лтд. / Нилсон Козы Ко., Лтд.

– Гималайн орнууд– Балба,Түвд

( Өвөрмэц сонирхлын аялал жуулчлалын нилээд хөгжсөн чиглэлүүд бөгөөд байгаль, соёлын хувьд дэлхийн хэмжээний сонирхол татахуйц баялаг нөөцтэй, ялангуяа түүх дурсгалын газрууд ,амьдралын уламжлалт байдал нь онцгой сонирхол татдаг)

Монголын хувьд бол Японоос жуулчин авах чиглэлээр зах зээлийг хөгжүүлэх ихээхэн давуу тал бий.

– Газар зүйн байршлын хувьд ойрхон, түүнчлэн өвөрмэц цаг уур, байгаль орчин, хүн ард, Японд хамгийн ойрхон орших говь нутаг г. м.

– Монгол нь " Гүн хөх тэнгэр, уудам хээр тал, нүүдэлчдийн орон" гэсэн сэтгэгдэл, төсөөлөл япончуудын дунд бүрэлдэн тогтсон .

– Монголд элэгтэй төрөл бүрийн салбарын алдартнууд олонтаа байдаг (зохиолч, бүтээлч,телевизийн одод г.м.)

– Дээрх судалгааны дүнгээс үзэхэд дахин буцаж ирэх сонирхолтой жуулчид нэлээд олон байна.

Иймд хэрвээ зохистой стратегийг авч хэрэгжүүлж чадвал Японы жуулчлалын зах зээлийг хөгжүүлэх нөөц боломж их байна .

### Өрнөдийн зах зээл

1997 онд дорхи хүснэгтэд үзүүлснээр Европоос 14000 жуулчин Монголд ирсэн байна.

Европын жуулчдын хувьд Монгол нь Азиас амьдралдаа нэг л удаа очиж үзэхэд хангалттай гэсэн орны тоонд орж байхад Тайланд (Пүкет), Индонез (Бали) нь далайн эргийн амралтын бүс гэдгээрээ дахин очих сонирхлыг төрүүлдэг. Өнөөгийн байдлаар Монгол нь зөвхөн байгаль, соёлын хүрээний сонирхол хосолсон төдий бус ан агнах, эртний амьтдын үлдцийг эрж хайх гэх зэрэг тодорхой зорилго бүхий өвөрмэц сонирхлын аялал жуулчлалын нэг чиглэл болж байгаа учир бага хэмжээний, хязгаарлагдмал зах зээл болж байна.

1997 он	Жуулчлал	Бизнес	Бүгд
АНУ	1857	1511	3368
Австрали	371	442	813
Хойд Европ	1535	865	2400
Их Британи	799	1273	2072
Өмнөд Европ	626	353	979
Франц	1271	400	1671
Герман	1469	1102	2571
Швейцарь	598	337	935
<b>Бүгд</b>	<b>8526</b>	<b>6283</b>	<b>14809</b>

Эх сурвалж: ЖАЙКА– гийн Судалгааны баг

## Дорнод Ази

Дорнод Азийн хувьд жуулчдаас бизнесийн хүмүүс ирэх нь илүүтэй байна.

1997 он	Жуулчлал	Бизнес	Бүгд
БНСУ	1285	1680	2965
Зүүн Ази	644	842	1486
Бүгд	1929	2522	4451

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Судалгааны баг

### 2) Аялалын үлгэрчилсэн загвар

Японы групп жуулчдын 8 өдрийн үлгэрчилсэн программ нь:

- Улаанбаатарт 3 хоног ( хүрэлцэн ирэх, бусад чиглэлд шилжих, буцаж явах)
- Улаанбаатарын орчим дахь жуулчдын гэр баазад 2 хоног
- Өмнөговь дахь жуулчдын гэр баазад 2 хоног байх жишээтэй.

Японы групп жуулчдын аяллын гол маршрут нь үндсэндээ Улаанбаатар, түүнээс 30– 80 км алсад орших хот орчмын газар болон Хархорин, Өмнөговь төдийгөөр хязгаарлагдаж байна.

Европын жуулчдын хоёр долоо хоногийн үлгэрчилсэн программ нь (жишээлбэл, Германы жуулчдын ) дараах аяллуудаас бүрдэж байна. Үүнд:

- Улаанбаатарт 5 хоног ( хүрэлцэн ирэх, бусад чиглэлд шилжих, буцаж явах )
- Хархорин, Хужирт, Бүрдийн гэр баазад 3 хоног
- Өмнөговийн гэр баазад 3 хоног
- Тэрэлж буюу Сэлэнгийн гэр баазын аль нэгийг сонгож 2 хоног

3 долоо хоногийн уртасгасан программ нь ( жишээлбэл, Францын жуулчдын) дээр дурдсан дээр нэмж Сэлэнгэ, Архангай, Хоргын уулс зэрэг газрыг хамарч байна.

Хээр тал, хөнгөн адал явдал, түүх соёлын дурсгалт газруудтай танилцах программууд Японы жуулчдын сонирхлыг татаж байхад, Европын аялагчид нь авто машинаар аялах, тэмээ унах, уул асгадад авирах зэрэг илүү төвөгтэй хэлбэрүүдийг сонгодог байна. Зах зээл дээр ноёлж буй жуулчлалын түгээмэл жишгүүдийг 3 дугаар хүснэгтэд үзүүлэв.

## 2.2 Аялал жуулчлалын нөөц, материаллаг бааз

### Жуулчлалын бүс нутгууд

Аялал жуулчлалын нөөц, жуулчдын сонирхол, тээврийн нөхцөл ( гол нь нислэгийн зам, орон нутгийн онгоцны буудлын бололцоо ) зэргийг харгалзан аялал жуулчлалын гол чиглэлүүдийг 2.3 дугаар хүснэгтэд үзүүлснээр 15 бүс нутагт хувааж байна.

### Түүхийн болон соёлын нөөц




2.4 дүгээр хүснэгтэд үзүүлсэнчлэн Монгол орон нь түүх соёлын дурсгалт үзмэрээр баялаг. Гэхдээ тэдгээрийн ихэнхийг, ялангуяа манай судалгааны гол загвар болсон Улаанбаатар, Хархорин дахь үзмэрийг жуулчдын сонирхол татахуйц хэмжээнд хүргэхийн тулд зохих ёсны судалгаа явуулан сэргээн засварлаж хамгаалалтад авах шаардлагатай байна.

### Халуун рашаан

Монголын галт уулын геологийн тогтоц нь нэлээд тооны халуун рашааны ундрагатай байх нөхцөлийг бүрдүүлжээ. Тэдгээрийн заримыг, жишээлбэл Хархорины орчим дахь Хужиртын рашааныг эмчилгээ сувиллын зориулалтаар ашиглаж ирсэн ч эдийн засагт гарсан өөрчлөлтийн улмаас рашаан сувиллаар үйлчлүүлэх явдал эрс багассан хэдий боловч тэдгээрийг амралтын газар болгон хөгжүүлэх өргөн боломж байна.

## 2.3 Аялал жуулчлал хариуцсан засгийн газрын байгууллагууд

- Дэд бүтцийн хөгжлийн яам нь аялал жуулчлалын салбарын удирдлагыг хэрэгжүүлж байна. Байгаль орчныг хамгаалах яам, Шинжлэх ухаан, технологи, боловсрол, соёлын яам, Улаанбаатар хотын захиргаа, аймгуудын аялал жуулчлалын хэлтэс, Монголын аялал жуулчлалын холбоо, Монголын зочид буудлуудын холбоо нь эко– жуулчлал хөгжүүлэх, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах, аялал жуулчлалыг бүхэлд нь хөгжүүлэх асуудлыг хариуцаж байна.
- Засгийн газрын хэрэгжүүлэх агентлагийн статустай Аялал жуулчлалын үндэсний төвийг 1998 онд байгуулсан ажээ.
- Дэд бүтцийн хөгжлийн яамны харьяанд 1998 онд Аялал жуулчлалын үндэсний зөвлөлийг байгуулсан нь аялал жуулчлалын асуудлаар засгийн газрын байгууллагуудын ажлын уялдаа холбоог бэхжүүлэхэд чиглэсэн юм.
- Аялал жуулчлалын хуулийн төслийг 2 ч удаа боловсруулж өргөн барьсан хэдий боловч өнөөдөр Монголд аялал жуулчлалын тухай бие даасан хууль батлагдаж гараагүй хэвээр байна.




- 1) Өлгий
- 2) Ховд
- 3) Увс
- 4) Хөвсгөл
- 5) Баянхонгор
- 6) Хархорин
- 7) Улаанбаатар
- 8) Өмнөговь
- 9) Хэнтий
- 10) Сүхбаатар
- 11) Дорнод
- 12) Сэлэнгэ
- 13) Завхан
- 14) Говь-Алтай
- 15) Дорноговь

МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН
ЯОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛАГАНЫ АЛЕНГЛАГ (МАРКА)
МОНГОЛ УЛСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ
Хүснэгт 2.2 Томоохон зах зээл дээр ноёдж буй түгээмэл багц хөтөлбөрүүдийн жишгүүд
ПАДЕКО Ко., Лтд. / Нилп Коой Ко., Лтд.

Энэ шэйл Зийёяу Зйээуживы үө Тйрүж Ыгүжйө  
Тйжоуэы





Хүснэгт 2.4 Монголын соёлын өвийн байршил

### **3. ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО, СТРАТЕГИ**

#### **3.1 Аялал жуулчлалыг хөгжүүлэх ерөнхий стратеги**

Засгийн газраас дэвшүүлсэн үндсэн зорилтыг хэрэгжүүлэх үүднээс жуулчны зах зээлийн давуу, сул тал, нөөц боломж, сөрөг нөлөөллийн талаар хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан түүнээс урган гарах дараахь стратегийг тодорхойлов. Үүнд:

##### **1) Газар нутаг ба хүмүүсийн өвөрмэц хослол бүхий зах зээл**

Гадаадын жуулчдын нүдэнд Монгол нь тал нутаг хүн ардын өвөрмэц хослол бүхий орон хэмээн харагддаг нь жуулчлалыг хөгжүүлэх хамгийн үнэ цэнтэй нөөц юм. Иймд үүнийг иш үндэс болгон аялал жуулчлалыг хөгжүүлэх бүхий л хүчин чармайлтыг хэрэгжүүлбэл зохино. Монголын талын онцын хүч чармайлт, оролцоогүйгээр Монголын аялал жуулчлалын талаархи нийтлэг ойлголт төсөөлөл дэлхийн жуулчлалын зах зээлд эдүгээ нэгэнт бүрэлдэн тогтсон хэдий ч түүнийг цаашид бэхжүүлэхээр ажиллах шаардлагатай байна.

##### **2) Байгалийн унаган төрхийг хамгаалж сурталчлах**

Байгалийн унаган төрхийг хамгаалахад байнга анхаарч ажиллах ёстой.

##### **3) Соёлын аялал жуулчлалыг дэмжих, хөгжүүлэх**

Өнөөгийн Монголын хувьд соёлын аялал жуулчлалыг цаашид өргөжүүлэх ихээхэн боломж байгаа билээ. Түүх соёлын өвийг сэргээн засварлаж, Монголын аялал жуулчлалын үндсэн давуу талтай хослуулан сурталчилж чадваас жуулчдын эрэлт хэрэгцээг хангаж, тэдэнд цаг, мөнгөө зарцуулах сонирхол төрүүлэх бөгөөд ингэснээр аялал жуулчлалын салбарыг өргөжүүлэх боломж нээгдэнэ.

##### **4) Дээрх гол гол чиглэлийг дэмжих зорилгоор материаллаг баазыг бэхжүүлэх, бусад үйл ажиллагааг явуулах**

Дээрх 3 гол чиглэлийг үндэс болгон маркетингийн хөтөлбөр, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ, материаллаг баазыг бэхжүүлэх асуудлыг хэрэгжүүлэх бодитой үйл ажиллагаа явуулах шаардлагатай байна. Аялал жуулчлалын материаллаг бааз, музей, хөшөө дурсгалын газруудыг бэхжүүлэн төвхнүүлэх хэрэгтэй байна.



### 5) Хүний нөөцийг хөгжүүлэх

Засгийн газрын болон хувийн секторт ажиллах аялал жуулчлалын мэргэжлийн дадлага туршлага бүхий ажилчдын тоог нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Улсын өмчийн салбарын хүрээнд, тухайлбал салбарын хөгжлийг төлөвлөх, менежментийг хэрэгжүүлэх, байгаль орчны менежментийг төлөвлөх, үндэсний хэмжээний сурталчилгаа, маркетингийн бодлогыг боловсруулах чадвартай мэргэжлийн боловсон хүчин шаардагдаж байна. Хувийн хэвшлийн хүрээнд, зочид буудал, гэр бааз, зоогийн газар болон бусад үйлчилгээний байгууллагад илүү чанартай үйлчилгээ явуулж чадах мэргэжлийн ажилчдыг сургаж бэлтгэх шаардлагатай байна. Түүнчилэн хөрөнгө оруулалтыг төлөвлөх асуудлаар ажиллах мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байна.

### 6) Дэд бүтцийг сайжруулах

Монгол дахь аялал жуулчлалыг цаашид хөгжүүлэх асуудлыг чухалчилж үзвэл нэн тэргүүнд олон улсын болон дотоодын агаарын тээвэрт мэдэгдэхүйц ахиц гаргах хэрэгтэй. Түүнчлэн жуулчдад зориулсан амралтын болон бие засах газруудыг сайжруулах зэрэг дэд бүтцийн чанартай арга хэмжээг авч явуулах хэрэгтэй байна. Аялал жуулчлалын газар нь тус салбарын эрх ашгийг хамгаалж, дэд бүтцийг хөгжүүлэх асуудлыг хариуцсан төрийн байгууллагад энэ талаар байнгын шахалт шаардлага тавьж байх нь зүйтэй.

### 7) Үйлчилгээг сайжруулах

Аялал жуулчлалын салбар дахь үйлчилгээний чанарыг дэлхийн өнөөгийн төвшинд өрсөлдөхүйц хэмжээнд хүртэл сайжруулах шаардлагатай байна. Тус салбарыг олон улсын үйлчилгээний төвшинд хүргэх арга зам нь чухамхүү ажил хэргийг гардан гүйцэтгэж буй хүмүүс ажлаа өдөр тутам тогтмол өндөр зэрэглэлд явуулж дадах явдал мөн. Түүнчилэн, дэлхийн төвшинд хүрсэн үйлчилгээ бүхий газруудыг ч байгуулуштай.

## 3.2 Аялал жуулчлалын эрэлт хэрэгцээний төлөв

Гол гол зах зээлийн эрэлт хэрэгцээний өсөлтийн таамаг тооцоонд үндэслэн аялал жуулчлалын эрэлт хэрэгцээний төлөвийг тодорхойлов.

### ( 2000 он хүртэлх эрэлт хэрэгцээ )

Энэхүү судалгаанд санал болгож байгаа төсөл хөтөлбөрийг ( жишээлбэл удирдлагын арга хэмжээнүүд, дэд бүтцийг хөгжүүлэх, үйлчилгээний төвшинг дээшлүүлэх гэх мэт) бүгдийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд ч тэдгээрийг нарийвчлан боловсруулах, хэрэгжүүлэх бэлтгэл хангах ( тухайлбал, засгийн газар хоорондын хоёр талын гэрээ хэлцэл байгуулах )—ад хугацаа хэрэгтэй тул 2000 оноос өмнө ямарваа нэгэн төсөл

хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх боломжгүй. Иймд 1999 онд төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн гэсэн үзүүлэлтийг тусгаагүй болно.

**( 2015 он хүртэлх эрэлт хэрэгцээ )**

Жуулчдын нийт тоо, жуулчин / хоногийн хэтийн төлөвийг төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлээгүй гэсэн хоёр хувилбараар тус тусад нь тооцож гаргалаа.

**" Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн тохиолдолд "**

Судалгаанд санал болгосон бүх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлснээр аялал жуулчлалын эрэлт хэрэгцээ эрчимтэй өснө.

**" Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй тохиолдолд "**

Судалгаанд санал болгосон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар хугацаа алдаж хойшлогдсон тохиолдолд өсөлт буурна. Гэхдээ агаарын тээврийг өргөжүүлэх, зочид буудлын багтаамжийг нэмэгдүүлэх замаар аялал жуулчлалын ердийн өсөлтийг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

**Гадаадаас ирэгчдийн тоо**

( мянгаар )


	1997	2000	2005	2010	2015
Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн тохиолдолд	81	109	182	275	414
( Үүний дотор япончууд )	11	18	40	67	109
Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй тохиолдолд	81	107	172	242	347
( Үүний дотор япончууд )	11	17	35	52	78

**Жуулчдын тоо**

( мянгаар )


	1997	2000	2005	2010	2015
Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн тохиолдолд	22	37	74	130	210
( Үүний дотор япончууд )	9	16	35	60	98
Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй тохиолдолд	22	35	64	96	143
( Үүний дотор япончууд )	9	15		30	44

Гадаадаас ирэгчдийн 2015 он хүртэлх хэтийн төлөв  
 ("хөтөлбөр/ төслийг хэрэгжүүлсэн" тохиолдолд)




Эх сурвалж: ЖАЙКА-гийн Судалгааны баг

Гадаадаас ирэгчдийн 2015 он хүртэлх хэтийн төлөв  
 ("хөтөлбөр/ төслийг хэрэгжүүлээгүй" тохиолдолд)




Эх сурвалж: ЖАЙКА-гийн Судалгааны баг

Гадаадаас ирэгчдийн 2015 он хүртэлх хэтийн төлөв  
("хөтөлбөр/ төслийг хэрэгжүүлсэн" тохиолдолд)



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Судалгааны баг

Гадаадаас ирэгчдийн 2015 он хүртэлх хэтийн төлөв  
("хөтөлбөр/ төслийг хэрэгжүүлээгүй" тохиолдолд)



Эх сурвалж: ЖАЙКА-гийн Судалгааны баг

### 3.3 Бүс нутгийн хөгжлийн стратеги

Аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөц бололцоог үнэлж дүгнэсний үндсэн дээр Монголын аялал жуулчлалын хөгжлийн зорилго, стратегийг харгалзан аялал жуулчлалыг хөгжүүлэх бүс нутгийн талаар хийсэн судалгааны үр дүн, зэрэглэлийг дараах хүснэгтэд үзүүлэв. Улаанбаатар, Хархорин, Өмнөговь гэсэн чиглэлүүдийг тэргүүн зэрэгт, Хөвсгөл болон баруун зүгийн нутгууд (ялангуяа Өлгий), Хэнтий (Дадал, Дэлгэрхаан), Дорноговь гэсэн чиглэлүүдийг удаахь зэрэгт, Баянхонгор, Шилийн Богд, Дорнод, Дархан, Говь– Алтай, Завхан зэрэг бусад чиглэлүүдийг доогуур зэрэглэлд оруулсан болно.

Аялал жуулчлалын чиглэлүүдийг харьцуулсан үнэлгээ

		Зах зээлийн төлөвшилт	Аялал жуулчлалын байгаа нөөц	Аялал жуулчлалын нөөцийн чадаахи	Аялал жуулчлалын материаллаг бааз (зочид буудал, рөсторан г. м.)	Дэд бүтэц	Ерөнхий үнэлгээ (зэрэглэл)
1	Улаанбаатар, түүний орчин	OO	Δ	Δ	O	O	A
2	Хархорин	OO	Δ	O	O	x	A
3	Өмнөговь	O	O	OO	O	x	A
4	Хөвсгөл	Δ	O	O	Δ	x	B
5	Хэнтий (Дадал, Дэлгэрхаан)	Δ	Δ	O	Δ	x	B
6	Баруун аймгууд (Өлгий, Ховд, Увс)	x	x	OO	x	x	B
7	Дорноговь	x	x	O	x	O	B
8	Баянхонгор	x	x	O	x	x	C
9	Мэнэн, Буйр, Дорнод	x	x	O	x	x	C
10	Шилийнбогд, Сүхбаатар	x	x	Δ	x	x	C
11	Булган, Сэлэнгэ	x	x	O	x	x	C
12	Говь– Алтай	x	x	Δ	x	x	C
13	Завхан	x	x	Δ	x	x	C

Аялал жуулчлалын дээрх чиглэлүүдийг харьцуулсны үндсэн дээр Монголд олон улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх гол чиглэл хандлагыг дор дурдсанаар тодорхойлж байна.

Ойрын хугацааны хөгжлийн чиглэл (2005)

Аялал жуулчлалыг хөгжүүлэх анхдагч цөм: "А" зэрэглэлийн бүс нутаг, Улаанбаатар, Хархорин, Өмнөговь

Өвөрмэц сонирхлын аялал жуулчлалын чиглэлүүд: "Б" зэрэглэлийн бүс нутаг, Хөвсгөл, Хэнтий, Баруун аймгууд, Дорноговь


Урт хугацааны хөгжлийн чиглэл (2015)


Аялал жуулчлалыг хөгжүүлэх анхдагч цөм: "А" зэрэглэлийн бүс нутгууд

Аялал жуулчлалын 2 дугаар зэргийн чиглэлүүд: "Б" зэрэглэлийн бүс нутгууд

Өвөрмэц сонирхлын аялал жуулчлалын чиглэлүүд: "В" зэрэглэлийн бүс нутгууд

Ойрын болон урт хугацаанд бүс нутгийг шатлан хөгжүүлэх төлөвлөгөөг 3.1 болон 3.2 дугаар хүснэгтэд үзүүлсэн болно.







### 3.4 Аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө

#### 1) Түүх соёлын газруудтай танилцах аялалыг дэмжих

– Монголын түүх соёлын үнэт зүйлсийн талаар судалгаа явуулах, тэдгээрийг хамгаалах, засварлан сэргээх, мөн түүх соёлын дурсгалт газруудад хүрэх зам тээврийг сайжруулах, жуулчдад зориулан түүх соёлын үнэт зүйлсийн талаархи мэдээллийг бэлтгэж түгээх зэрэг ажлыг зохион байгуулах. Жуулчдын сонирхож буй түүх соёлын дурсгалт газрууд нь өргөн уудам нутгаар тархан байрласан тул тэдгээрт хэрхэн хүрч очих тухай тодорхой танилцуулга гаргах, тэнд зочдыг хүлээн авах төвүүдэд алжаал тайлж амрах газруудыг бий болгон тохижуулах явдал чухал ач холбогдолтой.

– Соёлын нөөцийг судлах, хамгаалж хөгжүүлэх зэрэг асуудлыг эрхэлж буй аялал жуулчлалын асуудал эрхэлсэн байгууллагуудын, тухайлбал Гэгээрлийн яамны (төрийн захиргааны төв байгууллага) болон Түүх соёлын үнэт зүйлсийг хамгаалах сангийн (засгийн газрын бус байгууллага) үйл ажиллагааг эрчимжүүлэх.

– Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн үзэсгэлэн, музей, үзвэрийн газруудын талаархи танилцуулга, мэдээллийн дэлгэц материалыг олшруулах, тайлбарлагч, үйлчилгээг сайжруулах.

#### 2) Нүүдлийн соёлтой танилцах аялал жуулчлалыг дэмжих

– Нүүдлийн соёлыг аялал жуулчлалын нэг тодорхой нөөц болгон ашиглах (жишээлбэл, Монголын Соёлын Хүрээлэнг байгуулж хөгжүүлэх, нүүдлийн ахуй амьдралын талаар нүүдэлчид өөрсдөө танилцуулах г. м.)

– нүүдэлчин малчдын бүтээсэн эд зүйлсийг сурталчилж олны хүртээл болгох ( тухайлбал, гар урлалын бүтээгдэхүүн, цагаан идээгээр бэлэг дурсгалын дэлгүүр, зочид буудлыг хангах)

– нүүдэлчдийн ахуй амьдралын чиглэлээр аялал жуулчлалын үйлчилгээг хөгжүүлэх (морь унах ,эсгий хийхийг зааж сургах г. м.)

#### 3) Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг өргөжүүлэх

##### Улаанбаатар хотыг аялал жуулчлалын гол төв болгон хөгжүүлэх

( Хот орчмын хөгжлийн талаар)

– Жуулчдын сонирхлыг татахын тулд жуулчдад зориулсан гудамж талбай, үйлчилгээний төвүүдийг бий болгож хөгжүүлэх

– Хагас буюу бүтэн өдрийн аялалын программ, маршрутыг дэмжиж зохион байгуулах

– Монгол орон, Улаанбаатарын талаар жуулчдад зориулсан мэдээлэл, танилцуулгыг нэмэгдүүлэх

( Улаанбаатар хот орчмын бүс нутгийг хотын иргэд, гадаадын байнга оршин суугаа иргэдийн оролцоотойгоор хөгжүүлэх)

- Хот орчмын бүс нутагт салхинд гарч амрах бололцоо бүхий газруудыг байгуулах
- Байгалийн сэдэвт хүрээлэнгүүд байгуулах (шувуудын хүрээлэн, морь унах хүрээлэн)
- Спортын шинэ төрлүүдийг нэвтрүүлж хөгжүүлэх ( агаарын бөмбөрцөг унадаг дугуй г.м. )
- Спортын бусад төрлүүдийг шинээр нэвтрүүлэх (цана, гольф )

**Аялал жуулчлалын шинэ үйл ажиллагааг дэмжиж сурталчлах**

**Спортын болон галт тэргээр аялах аялалыг дэмжиж хөгжүүлэх**

	Богино хугацаанд	Урт хугацаанд
Газрын спортын төрлүүд	Уулын бартаат замаар дугуйгаар аялах	Бартаат явган аялал
Агаарын спортын төрлүүд	Агаарын бөмбөрцөг Машинаар хөтлүүлж шүхрээр нисэх Шүхрээр буух Дельтаплан	Агаарын чөлөөт уналт
Усан дээрх спортын төрлүүд	Загас барих	Завиар явах Салаар аялах
Аялал жуулчлалын галт тэрэг	Говь(Улаан Уул) хүртэлх аялал	Оросын хил хүртэлх аялал

### 3.5 Систем/зохион байгуулалтыг хөгжүүлэх төлөвлөгөө

Ангилал	Үйл ажиллагаа	Агуулга
Төрийн захиргаа- Ны байгууллагууд/ Удирдлагын асуудлууд	Аялал жуулчлалын Үндэсний төвийг байгуулах	Аялал жуулчлалын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх
	Аялал жуулчлалын чиглэлээр орон нутгийн засаг, захиргааны байгуулла- гуудыг бэхжүүлэх	Томоохон аймаг, орон нутгийн засаг, захиргааны байгуулла- гуудад аялал жуулчлал эрхэлсэн хэлтсүүдийг байгуулах, орон нутгийн засаг захиргааны бай- гууллагуудын үйл ажиллагаанд аялал жуулчлалын хэлтсийн тэргүүлэх үүргийг хүчтэй болгох
	Лиценз, зөвшөөрөл олгох болон аюулгүй байдлыг хангах талаар тавих хяналтыг сайжруулах	<ul style="list-style-type: none"> <li>- Аялал жуулчлалын лиценз, зөвшөөрөл олгоход тавих хяналтыг хүчтэй болгох</li> <li>- Газар ашиглалтад хяналт тавих, зөвшөөрлийн систем тогтоох</li> <li>- Аюулгүй байдлын жишиг, түв- шинг сайжруулах</li> <li>- Зочид буудал, зоогийн газрын үйлчилгээний зэрэглэлийг тогтоох</li> </ul>
	Олон түмэнд таниулж мэдүүлэх программ	Материал бэлтгэх, уулзалт зохион байгуулах, сургуулиудад хичээл заах, сурагчдын аялал зохион байгуулах г.м.
Хувийн хэвшлийн Нийгэмлэг, холбоо	Зочид буудлууд	<ul style="list-style-type: none"> <li>- Семинар, сургалтыг зохион явуулах замаар зочид буудлуу- дын үйлчилгээний чанарыг дээшлүүлэх</li> <li>- Монголын зочид буудлуудын холбоог сурталчлах зорилгоор гадаад орнуудын зочид бууд- луудын холбоодтой харилцаа тогтоож ажиллах</li> </ul>
	Жуулчны байгууллагууд	- Монголын аялал жуулчлалын үндэсний холбооны гишүүнч- лэлийг бий болгож аялалын

		<p>шинэ хөтөлбөрүүдийг зохиох</p> <ul style="list-style-type: none"> <li>-- гадаад орнуудын аялал, жуулчлалын холбоодтой харилцаа, хэлхээ холбоогоо сайжруулах</li> </ul>
	Зоогийн газрууд	<ul style="list-style-type: none"> <li>-- Монголын зочид буудлуудын холбоог дэмжиж, гишүүний тэмдгийг бий болгох</li> <li>-- Тогооч, үйлчилгээний ажилтнуудыг шагнаж урамшуулах замаар үйлчилгээний чанарыг сайжруулах</li> </ul>
Урамшууллын Хөшүүрэг	Аялал жуулчлалын салбарт гадаадын хөрөнгө оруулах явдлыг дэмжиж урамшуулах	<ul style="list-style-type: none"> <li>-- Эхний 3 жилд орлогын татвараас чөлөөлөх, дараагийн 3 жилд татварыг 50 хувиар хөнгөлөх ( 4 таван хошуу бүхий зочид буудлуудад)</li> <li>-- Эхний 5 жилд орлогын татвараас бүрэн мөсөн чөлөөлөх, дараагийн 5 жилд татварыг 50 хувиар хөнгөлөх (жишээлбэл, өвлийн жуулчлалыг хөгжүүлсэн байгууллагад)</li> <li>-- Жуулчны гэр баазуудыг сайжруулж хөгжүүлсэн тохиолдолд татвараас чөлөөлөх</li> <li>-- Тодорхой бүс нутагт аялал жуулчлалын цогцолборыг хөгжүүлэх явдлыг дэмжих ( тухайлбал, байнга ашиглаж болох, зардал багатай, авсаархан төсөр г.м.)</li> </ul>
Маркетинг	Гадаад орнуудад маркетингийн үйл ажиллагаа явуулах	<ul style="list-style-type: none"> <li>-- Гадаадын хөрөнгө оруулах асуудлаар бизнесийн семинар зохион байгуулах</li> <li>-- Гадаадад зохиогдож буй аялал жуулчлалын сэдэвтэй үзэсгэлэн, яармагт оролцох</li> <li>-- Дэлхийн аялал жуулчлалын томоохон байгууллагуудтай нягт холбоо тогтоож ажиллах</li> <li>-- "2005 онд Монголд зочилно уу" гэсэн уриалгыг дэвшүүлэх</li> <li>-- Олон улсын хурал, зөвлөлгөөнд идэвхитэй оролцох</li> <li>-- Гадаад орнуудад өөрийн төлөө</li> </ul>

	Монгол дахь маркетингийн үйл ажиллагаа	<p>лөгчийн газруудыг нээх</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрөл бүрийн сурталчилгааны материал бэлтгэх ( видео болон хэвлэсэн танилцуулга г.м.)</li> <li>- Олон нийтийн арга хэмжээ, фестиваль, олон улсын хурал, зөвлөлгөөн зэргийг идэвхтэй зохион байгуулах</li> <li>- Наадмын баяр ёслолын ажиллагааг өргөжүүлэх (жишээлбэл, олон улсын урлагийн байгууллагын үйл ажиллагаанд оролцох)</li> </ul>
--	--	--

### 3.6 Дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөгөө

#### Авто замыг хөгжүүлэх төлөвлөгөө

- Улаанбаатар– Хархорины засмал замыг сайжруулах: Улаанбаатар–
- Хархорины хоорондох 380 км урт засмал зам нь аялал жуулчлалын гол зам тул автомашинаар дунджаар цагт 100 км хүртэл хурдлах боломжтой болгон сайжруулбаас аялалын хугацаа 4 цаг хүрч богиносно. ( 1 цаг илүүтэйгээр богиносч байгаа юм).
- Улаанбаатар– Өмнөговийн чиглэлийн замыг сайжруулах: 580 км урттай Улаанбаатар– Даланзадгадын хоорондох замын хучилтыг сайжруулан өргөн шулуун болгох урт хугацааны ( 2015 он хүртэлх) зорилтыг дэвшүүлж байна.
- Хархорины орчим ( Арвайхээр)– Өмнөговь (Сэврэй) чиглэлийн замыг сайжруулах: Хэтийн (2015 он хүртэлх) хугацаанд Хархорин, Өмнөговийн хоорондох замыг хайрган зам болгон сайжруулж Улаанбаатар, Хархорин, Өмнөговийг хооронд нь холбох.
- Бусад:
  - Улаанбаатар– Хархорины засмал зам зэрэг гол чиглэлийн замуудын дагуу зогсоол, түр амрах газруудыг барьж байгуулах
  - Замыг (ялангуяа, гол замуудыг) замын тэмдгээр бүрэн хангах
  - Автомашин түрээслэх системийг нэвтрүүлж хөгжүүлэх (урт хугацаанд)

#### Орон нутгийн агаарын тээврийг хөгжүүлэх

- Нислэгийн аюулгүй байдлыг хангах стратегийг гол зарчим болгон орон нутгийн агаарын тээврийг бэхжүүлэх, хувийн хэвшлийг илүү чөлөөтэй оролцуулах

- Онгоцны буудлуудын үйлчилгээний барилга байгууламжуудыг хувьчлах (Иргэний агаарын тээврийг удирдах газар нь нислэгийн аюулгүй байдлыг хянана)
- Орон нутгийн агаарын тээврийн үйлчилгээг чанаржуулах
  - суудлын захиалга хийх, зорчигч бүртгэх, онгоцонд суулгах системийг сайжруулах (ялангуяа, орон нутгаас Улаанбаатар буцах нислэгт)
  - орон нутгийн нислэгийн цагийн хуваарийг чанд мөрдөж занших
  - аюулгүй байдлыг бүрэн хангасан найдвартай онгоцыг нислэгт гаргах

### **Олон улсын агаарын тээврийн үйлчилгээг хөгжүүлэх төлөвлөгөө**

- Агаарын тээврийн үйлчилгээнд хамтын ажиллагааг нэвтрүүлэх бодлогыг баримтлах
- Засгийн газар хоорондын хоёр талын хэлэлцээр байгуулах
- Олон улсын агаарын тээврийн онгоцны компаниудын сүлжээнд нэгдэх
- Олон улсын нислэгийн үйлчилгээг сайжруулах

### **Бохир усны цэвэрлэх байгууламжийг сайжруулах**

Жуулчны гэр баазаас (50 гэр бүхий) өдөрт дөнгөж 20 шоо м бохир ус гардаг. Хэдийгээр цэвэрлэсэн бохир усны дээд хэсэг нь байгаль орчинг бохирдуулахгүй тул түүнийг илээр асгаж болох боловч хэрэгжүүлэлтийн шатанд уг асуудлыг дахин сайтар хэлэлцэх шаардлагатай. Урсгалын доод хэсэгт эмзэг объект байх тохиолдолд маш хянамгай няхуур хандах хэрэгтэй юм.

### **Харилцаа холбооны системийг сайжруулах**

Одоогийн байгаа харилцаа холбооны шугамуудыг (тоон системийн хэт богино долгионы болон ил утастай шугамууд) Өмнөговь дахь жуулчны гэр баазууд хүртэл уртасгах нь өндөр өртөгтэй болж байна. 2001 он гэхэд Иммарсат сансрын хиймэл дагуулын системийг нэвтрүүлэх нь зүйтэй.

### **Эрчим хүчний хангалтыг сайжруулах**

Техникийн дэвшлийг дагалдан зардал нь хямдарвал салхи болон нарны эрчим хүчний эх үүсгүүрийг ашиглах асуудлыг урт хугацааны зорилт болгон нарийвчлан судалж болох юм.

## **3.7 Хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө**

### **Аялал жуулчлалын мэргэжлийн сургалтыг сайжруулах**

Зочид буудал, зоогийн газруудыг дадлага туршлага бүхий ажилтнаар хангах зорилгоор тусгай мэргэжлийн сургуулиуд байгуулах, одоогийн курс дамжааг улам өргөжүүлэх шаардлага тулгарч байна. Өнөөгийн байдлаар Худалдаа

үйлдвэрийн дээд сургууль, Аялал жуулчлалын дээд сургууль нь уг сургалтын асуудлыг хариуцаж байгаа болно. Жуулчдын тоо өсөж байгаатай холбогдон 2015 он гэхэд ойролцоогоор 1000 тогооч, 800 үйлчлэгч нэмж шаардагдах тооцоо гарч байна. Энэхүү хэрэгцээг хангах үүднээс одоогийн байгаа курс сургалтыг цаашид илүү олон тооны оюутан хамруулахуйц болгон өргөжүүлэх хэрэгтэй.

### **Аялал жуулчлалын дээд мэргэжлийн боловсон хүчинг бэхжүүлэх**

Юуны өмнө дээд боловсролын чиглэлээр багш сургагч нарыг бэлтгэхэд анхаарах ёстой. Гадаадаас багш нарыг урьж ажиллуулах, аялал жуулчлал өндөр хөгжсөн орнуудад багш нарыг явуулж дадлагажуулах, оюутан сурагчдыг гадаадад сургах, сургалтын материалыг шинэчлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх хэрэгтэй юм.

Хичээлийн давхардлыг арилгах, зарим шаардлагатай хичээлийг нэмж оруулах замаар сургалтын хөтөлбөрийг дахин хянаж үзэх нь зүйтэй гэж Аялал жуулчлалын газар үзэж байна. Мэргэжлийн аялалын хөтөч-газарчид бэлтгэх иж бүрэн цогцолбор дамжаа сургалтыг зохион байгуулах хэрэгтэй байна.

### **Бусад арга хэмжээ**

Хувийн секторын боловсон хүчин, ялангуяа удирдах ажилтнуудыг давтан сургалтад хамруулах онцгой шаардлагатай байна. Зарим зочид буудлууд олон улсын сургалтын байгууллагуудад хүнээ явуулж сургах, түүнчлэн аялал жуулчлалын мэргэжлийн хүмүүсийг урьж ирүүлэн ажилтнуудаа дадлагажуулах зэрэг арга хэмжээ авч байгааг цаашид дэмжих нь зүйтэй.

Жуулчны гэр баазуудын ажилтнуудыг өвлийн цагт (жуулчид цөөн ирэх үед) сургалтад хамруулбал зохино. Худалдаа үйлдвэрийн болон Аялал жуулчлалын дээд сургуулиудыг түшиглэн Улаанбаатарт богино хугацааны дамжаа зохион байгуулж болох юм.

### **3.8 Байгаль орчны менежмент болон аялал жуулчлалын хөгжил**

#### **Байгаль орчны менежментийн хөтөлбөрүүд**

Аялал жуулчлалыг хөгжүүлэхийн зэрэгцээгээр Монгол орныг бүхэлд нь тусгай хамгаалалтын бүс нутаг болгох хөтөлбөрийг боловсруулах шаардлагатай байна. Байгаль орчны менежментийн асуудлаар одоогоор НҮБ-ийн Хөгжлийн программ, Дэлхийн онгон байгалийн сан, Германы Техникийн хамтын ажиллагааны сан зэрэг олон улсын байгууллагууд хамтран ажиллаж байна. Хүрээлэн буй орчныг хамгаалах менежментийн асуудлыг иж бүрэн цогцолбороор шийдэх үүднээс дор дурдсан стратегийн хөтөлбөрийг шинээр нэмж боловсруулах хэрэгтэй. Үүнд:

- Зэрлэг амьтан ургамлын менежментийн үндэсний хөтөлбөр
- Үндэсний чулуужсан малтмалын менежментийн хөтөлбөр
- Үндэсний эко- жуулчлалын сүлжээ хөтөлбөр
- Олон улсын эко- жуулчлалын сүлжээ хөтөлбөр
- Шувууд ажиглах үндэсний сүлжээ хөтөлбөр
- Эко- жуулчлалын болон байгалийн чиглэлийн аялалуудын аюулгүй байдлыг хангах менежментийн хөтөлбөр
- Нүүдлийн мал аж ахуйн газар ашиглалтын менежментийн хөтөлбөр

#### Нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай хөтөлбөрүүд

- Байгаль хамгаалагчид, эко- жуулчлалын хөтөч-газарчид, орчуулагчид болон хамгаалалтын бүс нутагт амьдарч буй хүмүүст зориулан тухайн бүс нутаг, түүний байгаль орчны менежмент, эко- жуулчлалын сэдвээр сургалт зохион байгуулах
- Тусгай хамгаалалтын бүс нутгийн талаархи танилцуулга мэдээллийг бэлтгэх
- Өндөр ууланд ургадаг ургамал, зэрлэг шувууд, ан амьтад, хэвлээр явагч/газар усны амьтад, загас, шавьжны үндэсний зурагт каталогийг бэлтгэн гаргах
- Онцгой тохиолдлын үед шуурхай нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулах
- Шувууд ажиглах үндэсний цогц газруудын сүлжээ байгуулах

### 3.9 Монгол Улсын эдийн засгийн хөгжилд аялал жуулчлалын оруулах хувь нэмэр

#### Монгол Улсын өнөөгийн байдал

1997 оны байдлаар үндэсний нийт бүтээгдэхүүний 4 орчим хувь нь аялал жуулчлалын салбарт ногдож буй нь Зүүн Өмнөд Азийн орнуудын төвшинд (1995 оны байдлаар 4.5 хувь) дөхөж очжээ гэсэн үг.

ҮНБ- нд аялал жуулчлалын олсон орлогын эзлэх хувь (одоогийн үнээр)


	1997
ҮНБ	737039
Аялал жуулчлалаас олсон орлого	29469
ҮНБ- нд эзэлж буй хувь	4.0

Эх сурвалж: ЖАЙКА- гийн Судалгааны баг



## Гадаад валютын орлого

Гадаад худалдааны экспорт 1996 онд 424,3 сая ам. долларт хүрснээс 29 сая ам. доллар (6.8 хувь) нь аялал жуулчлалд ногдож байна. Аялал жуулчлалын салбар хөгжихийн хирээр аялал жуулчлалын орлого түргэн хурдацтай өсч байна. Аялал жуулчлалын орлого 2015 он гэхэд 232 сая ам. доллараас давах тооцоо гарч байна.



Эх сурвалж: ЖАЙКА – гийн судалгааны баг<sup>1</sup>


## Ажлын байр бий болгох талаар оруулж буй хувь нэмэр

Аялал жуулчлалын салбарт ажил эрхлэгчдийн тоо 1997 онд ойролцоогоор 2300 байгаа нь нийт ажиллах хүчний (1.12 сая) 0.2 хувьтай тэнцэж байна. Аялал жуулчлалын салбарт ажиллагсдын тоо 2005 онд 4000, 2015 онд 12000 болох төлөвтэй байгаа нь нийт хүн амын жилийн өсөлт 1.4 хувь байхад аялал жуулчлалын салбарт ажиллагсдын тооны өсөлт жилдээ 10 хувь болж өсөх хандлагатай байна. Тиймээс ажлын байр шинээр бий болгох талаас нь авч үзвэл аялал жуулчлалын салбар эдийн засгийн ирээдүйн хэрэгцээг хангах ихээхэн боломж бүхий салбар юм.

<sup>1</sup> Энэ тооцоонд зөвхөн гадаадын жуулчдаас шууд орох орлогыг оруулсан болно. Ингэхдээ олон улсын тээвэрлэлтээс олох орлогыг хассан.

## Гадаад валютын орлого

Гадаад худалдааны экспорт 1996 онд 424,3 сая ам. долларт хүрснээс 29 сая ам. доллар (6.8 хувь) нь аялал жуулчлалд ногдож байна. Аялал жуулчлалын салбар хөгжихийн хирээр аялал жуулчлалын орлого түргэн хурдацтай өсч байна. Аялал жуулчлалын орлого 2015 он гэхэд 232 сая ам. доллараас давах тооцоо гарч байна.



Эх сурвалж: ЖАЙКА – гийн судалгааны баг<sup>1</sup>

## Ажлын байр бий болгох талаар оруулж буй хувь нэмэр

Аялал жуулчлалын салбарт ажил эрхлэгчдийн тоо 1997 онд ойролцоогоор 2300 байгаа нь нийт ажиллах хүчний (1.12 сая) 0.2 хувьтай тэнцэж байна. Аялал жуулчлалын салбарт ажиллагсдын тоо 2005 онд 4000, 2015 онд 12000 болох төлөвтэй байгаа нь нийт хүн амын жилийн өсөлт 1.4 хувь байхад аялал жуулчлалын салбарт ажиллагсдын тооны өсөлт жилдээ 10 хувь болж өсөх хандлагатай байна. Тиймээс ажлын байр шинээр бий болгох талаас нь авч үзвэл аялал жуулчлалын салбар эдийн засгийн ирээдүйн хэрэгцээг хангах ихээхэн боломж бүхий салбар юм.

<sup>1</sup> Энэ тооцоонд зөвхөн гадаадын жуулчдаас шууд орох орлогыг оруулсан болно. Ингэхдээ олон улсын тээвэрлэлтээс олох орлогыг хассан.

## 4. БҮС НУТГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

---

### 4.1 Улаанбаатар хотын орчин

#### 1) Хөгжлийн үндсэн бодлого стратегиуд

##### Бүс нутгийн хөгжлийн ерөнхий зарчим

- Агаараар болон газраар ( төмөр замаар) Монголд ирэх жуулчдыг анхлан хүлээн авдаг олон улсын гол төв болгох үүрэг ролийг нь бэхжүүлэх
- Суурин газрын аялал жуулчлалын бүх төрлийн үйлчилгээг үзүүлж чадах үндэсний төв болгох үйл ажиллагааг хүчтэй болгох
- Түүх соёл, уламжлалт ахуй амьдрал, соёл урлагийн чиглэлийн цэнгээнээс эхлэн бизнесийн арга хэмжээ, фестиваль, хурал цуглаан, уулзалт зөвлөлгөөн хүртэлх аялал жуулчлалтай холбогдолтой бүх хэлбэрийн үйл ажиллагааг идэвхжүүлэх
- Улаанбаатарын орчинд төрөл бүрийн сонирхолтой нэмэлт үйлчилгээ, арга хэмжээг зохион байгуулах

##### Хөгжлийн стратеги

- Улаанбаатар хотыг Монголын хот суурин газрын аялал жуулчлалын үйлчилгээний хамгийн том төв болгон бэлтгэж хөгжүүлэх
- Томоохон музей, жуулчид очдог гол газруудад үзэмжтэй танилцуулга, жуулчлалын мэдээлэл, бэлэг дурсгалын зүйлс зэргийг хийж тавих
- Түүх соёлын болон амралт цэнгээний зориулалттай барилга байгууламжуудыг (Богдын өвлийн музей, Гандан Тэгчлэн хийд, цирк г. м.) сэргээн засварлаж орчин үеийн жуулчлалын бүтээгдэхүүн болгон хувиргах
- Монгол дахь жуулчлалын гол төвийн хувьд хотын нэг хэсгийг жуулчдын онц сонирхол татахуйц аялал жуулчлалын цогцолборын хэлбэрээр (жуулчдын гудамж талбай, үйлчилгээний төв, зам маршрут, жуулчдын үзвэр үйлчилгээ зэргийг нэгтгэн ) засаж тохижуулах
- Жуулчлалын олон янзын шинэ бүтээгдэхүүн (тухайлбал, шувуудын хүрээлэн, морьдын хүрээлэн г.м.) нэвтрүүлэх
- Аялал жуулчлалтай холбоотой үйлдвэрлэлийг ( бэлэг дурсгалын зүйлсийн үйлдвэрлэл, худалдаа, зоогийн газрууд, цэнгээнт үйлчилгээ г.м.) сайжруулж хөгжүүлэх

#### 2) Аялал жуулчлалын эрэлт хэрэгцээний хэтийн төлөв

Улаанбаатар хотын аялал жуулчлалын эрэлт хэрэгцээг дор дурдсанаар төлөвлөв.

(жуулчин-хоног)

	Амралт зугаалгын чиглэлээр	Ажил хэргийн чиглэлээр	Бүгд
1997	94280	216841	311121
2005	306000	438000	744000
2015	862000	955000	1817000

### Зочид буудлын эрэлт хэрэгцээ

2005 он: Оргил ачааллын улиралд (7–8 дугаар сард) одоогоор байгаа зочид буудлуудын багтаамжаас бага зэрэг илүү хүчин чадлын хэрэгцээ гарах бөгөөд жуулчдын тоо цөөрөх улиралд ор ашиглалтын төвшин 50 хувиас доогуур байна.

2015 онд: 7–8 дугаар сард одоогоос 3 дахин илүү хүчин чадал шаардагдана.

### 3) Төлөвлөгөөний бүтэц, газар ашиглалт

Дээр дурдсан стратегийг хэрэгжүүлэхийн тулд 4.1, 4.2 хүснэгтэд үзүүлсэн 2005 он болон 2015 он хүртэлх хугацааны Улаанбаатар хотын хөгжлийн төлөвлөгөөг санал болгож байна. Эдгээр хүснэгтээс үзэхэд Улаанбаатар хотын орчинд аялал жуулчлалын онц сонирхолтой газруудыг хөгжүүлэх асуудал чухал байхын зэрэгцээгээр хотын гортиг дотор ч аялал жуулчлалын зорилгоор материаллаг баазыг шинэчлэх шаардлагатай нь тодорхой байна.

### 4) Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сайжруулах


Аялал жуулчлалын маршрут: Улаанбаатар хотын төв газруудаар жуулчлалын маршрут зохион байгуулах

Аялал жуулчлалын гудамж талбай: Улаанбаатар хотын захиргаа "Худалдааны гудамж– 2005" нэртэй хотыг шинэчлэх төслийг боловсруулж байна. Жуулчид олноор цугларах төвийг бий болгох зорилгоор жуулчдын гудамжийг энэхүү худалдааны дүүрэгт байгуулахыг санал болгосон .

Шувуудын хүрээлэн (Зэрлэг шувуудыг хамгаалах болон сургалт танин мэдэхүйн хүрээлэн): Улаанбаатар хотын урд хэсэгт зүүн зүгээс баруун тийш урсах Туул голын эргийн дагуу олон улсын нисэх онгоцны буудлын ойролцоо нүүдлийн шувууд олноор цугладаг газар бий. Тиймээс эдгээр шувуудыг аялал жуулчлалын байгалийн нэг нөөц болгон ашиглах, Улаанбаатар хотын оршин суугчид амралтаа өнгөрүүлэх бүс болгох үүднээс Шувуудын хүрээлэнг байгуулах асуудлыг санал болгож байна.

Морьдын хүрээлэн: Морьд, агтны музей, морь унаж сурах сургууль болон уралдааны зам (тойруулга) бүхий цогцолбор хүрээлэн байх нь зүйтэй.

### Улаанбаатарын орчинд аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого (2005 он хүртэл)




МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ  
 Я.ОНЫ ОРОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АГЛЭТЛЭГ (ОАЯЖА)

**МОНГОЛ УЛСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ  
 ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР  
 ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 4.1  
 Улаанбаатарын орчинд аялал жуулчлалыг  
 хөгжүүлэх бодлого (2005 он хүртэл)


ПАДЕКО Ко., Лтд. / Ниппон Коэй Ко., Лтд.

### Улаанбаатарын орчинд аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого (2005 он хүртэл)



МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
Я ОНЫ ОРОН УЛСЫН ХАМТЫН АЖЛАГААНЫ АГЕНТЛАГ (ЖАЙХА)
<b>МОНГОЛ УЛСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ</b>
Хүснэгт 4.1 Улаанбаатарын орчинд аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого (2005 он хүртэл)
ПАДЕКО Ко., Лтд. / Миллон Козы Ко., Лтд.

### Улаанбаатар хотын орчинд аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого (2015 он хүртэлх)



Морьд сургах урлаг, зэрлэг морьд хадгалан хамгаалах болон сургалтын төв


Онгоцны буудал

Жуулчид олноор очдог газарт хүрэх зам харгуйг сайжруулах

- Гүүр сайжруулах (УБ- Тэрэлж)
- Дөт зам сайжруулах (УБ- Манзшир)
- Онгоцны буудал хүрэх замыг сайжруулах
- Жуулчдын маршрут чиглэлийг зээсэн тэмдгүүд
- Автомашинь зогсоолуудыг сайжруулах
- Ая тух хангах байгууламжуудыг сайжруулах (бие засах газар гэх мэт)

МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛЭСН ЯАМ
Я.ОНЧ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛГААНЫ АГЕНТЛЭГ (ОАЯЖА)
<b>МОНГОЛ УЛСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВДӨГӨӨ</b>
Хүснэгт 4.2 Улаанбаатар хотын орчинд аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого (2015 он хүртэлх)
ПАДЕКО Ко., Лтд. / Ниглон Кооз Ко., Лтд.

### Улаанбаатар хотын орчинд аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого (2015 он хүртэлх)



МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
Я.ОЧИ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛГААЛЗЫ АГЕНТЛАГ (ЖАЯКА)
<b>МОНГОЛ УЛСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ</b>
Хүснэгт 4.2 Улаанбаатар хотын орчинд аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого (2015 он хүртэлх)
ПАДЕКО Ко., Лтд. / Нилпон Коэй Ко., Лтд.



**Гар урлалын төв:** Аялал жуулчлалын гудамжинд бэлэг дурсгалын зүйлсийн загварыг зохиох, үйлдвэрлэх, худалдаалах зорилгоор Гар урлалын төвийг байгуулахыг санал болгож байна.

**(Түүхийн дурсгалт газар, соёлын байгууламжууд)**

Богд хааны өвлийн ордон музей: Үзмэр, агуулах сав, хамгаалалтын систем болон захиргааны байгууламжуудыг сайжруулах, түүнчлэн Улаанбаатар хотын аялал жуулчлалын үүргийг бодолцон барилга байгууламжуудыг сэргээн засварлах шаардлагатай байна.

Монголын соёлын хүрээлэн: Улаанбаатар хотын орчинд Хархорин хүрэх гол замд нүүдэлчин ард түмний ахуй амьдралыг жуулчид сонирхон харж түүнд өөрийн биеэр оролцон туршиж болох энэ чиглэлийн сэдэвт хүрээлэн байгуулахыг санал болгож байна.

**(Хүрээлэн буй орчны талаар)**

Эко– жуулчлал, байгалийн аялал жуулчлалыг төлөвлөх ажилтнууд болон аялалын газарчид, багш сургагч нарыг бэлтгэх зорилгоор Улаанбаатарын мэргэжлийн сургуулиудад шинэ курс дамжааг зохион байгуулах шаардлагатай.

**5) Холбогдох дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөгөө**

**Замууд**

- Тэрэлж, Манзширийн хийд гэх мэтийн хотын ойр орчмын аялал жуулчлалын газруудад хүрэх замыг сайжруулах
- Замын зураг, тэмдэг, жуулчдад зориулсан мэдээллийн дэлгэц самбар, гэрэл дохионы байгууламжуудыг бий болгох

**4.2 Хархорины бүс нутаг**

**1) Хөгжлийн үндсэн бодлого стратегиуд**

**Бүс нутгийн хөгжлийн ерөнхий зарчим**

- Монголын соёлын жуулчлалын хамгийн дөт цэг (Хархорин)
- Хархорины соёлын үзвэрүүдтэй хамтатган ашиглаж болох бусад төрөл бүрийн нөөц боломж элбэг (Хужиртын рашаан сувилал, Орхоны хөндий)
- Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх ихээхэн нөөц бололцоо бүхий эрүүл мэнд, эмчилгээний зориулалтын хамгийн ойр дөт халуун рашаан

## Хөгжлийн стратеги

- Эрдэнэзууд үзэмжтэй танилцуулга, жуулчдын мэдээлэл бэлтгэж тавих, Эрдэнэзуугийн сэдвээр бэлэг дурсгалын зүйлс хийж худалдаалах
- Хархоринг бүхэлд нь археологийн болон соёлын иж бүрэн цогцолбор болгон тохижуулж сайжруулах ( Эрдэнэзуу, Хархорины балгас, Мэлхий хаданд хүрэх шинэ зам, автомашины зогсоол барьж байгуулах, замын тэмдгээр бүрэн тоноглох, газар нутгийг тохижуулах г. м.)
- Хар балгас, Хөшөө Цайдамд үзэмжтэй танилцуулга, жуулчдын мэдээлэл бэлтгэж тавих, уг газруудын сэдвээр бэлэг дурсгалын зүйлс хийж худалдаалах
- Орхоны хөндийд байгалийн жуулчлалын программ зохион явуулдаг болох, үзэмжтэй танилцуулга, жуулчдын мэдээлэл, уг газрын сэдэвт бэлэг дурсгалын зүйлсээр хангах
- Хөнгөн адал явдалт аялал болон бусад төрлийн арга хэмжээг Бүрд, Монгол элс, Элсэн манханд явуулдаг болох
- Хужиртын рашаан сувилалын газрын барилга байгууламжийг сайжруулах, ялангуяа дотоодын аялал жуулчлалын боломжийг ашиглах зорилгод чиглүүлэх.

### 2) Аялал жуулчлалын эрэлт хэрэгцээний хэтийн төлөв

Хархорины аялал жуулчлалын эрэлт хэрэгцээг дор дурдсанаар төлөвлөв.

	Бүгд (жуулчин– хоног)
1997	25481
2005	82000
2015	233000

### Зочид буудлын эрэлт хэрэгцээ

2005 он: 8дугаар сард эрэлт хэрэгцээ одоогийн байгаа зочид буудлуудын хүчин чадлаас 20 хувь давна.

2015 он: Оргил ачааллын улиралд эрэлт хэрэгцээ одоогийн байгаа зочид буудлуудын хүчин чадлаас 3 дахин нэмэгдэх тооцоо гарч байна.

### 3) Төлөвлөгөөний бүтэц, газар ашиглалт

Дээр дурдсан стратегийг хэрэгжүүлэхийн тулд 4.3, 4.4 хүснэгтэд үзүүлсэн 2005 он болон 2015 он хүртэлх хугацааны Хархорины хөгжлийн төлөвлөгөөг санал болгож байна. Түүхийн томоохон үнэт цогцолбор болох Хархорины Эрдэнэзуу, Хөшөө Цайдам дахь Түргийн хөшөө, Хар Балгасын Уйгарын хэрэм болон Хархорин, Хөшөө Цайдам, Хар Балгасыг хооронд нь

холбосон замыг барьж байгуулахтай хамтатган сайжруулж 2005 он гэхэд дуусгахаар төлөвлөсөн. Нүүдлийн шувууд олноор цугладаг Өгий нуурыг дайруулан Хоргын галт уулын орчинтой холбосон хойд чиглэлийн аялал жуулчлалын замыг хэт нь барьж байгуулах асуудлыг тусгав. Тус бүс нутгийн өмнө хэсэгт орших Хангайн нурууны дархан цаазат газар Орхон голын дагуу олон хүрхрэнүүд бий. Эдгээрийг аялал жуулчлалын цэг болгон ашиглах, түүнчлэн Хужиртын рашаан сувилалыг дайруулан тэдгээрт хүрэх замыг барьж байгуулах явдлыг урт хугацааны зорилт болгон төлөвлөв.

#### 4) Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сайжруулах

##### **Зочдыг хүлээн авах төвийг байгуулах**

Эрдэнэзуутай залгуулан Зочдыг хүлээн авах төвийг барьж байгуулахыг санал болгож байна. Уг төвд Хархорины түүхийг тайлбарлан танилцуулах тусгайлан сонгосон үзмэрүүдийг дэлгэн тавьсан байх юм. Мөн Эрдэнэзууг арчилж тордох болон захиргааны үүргийг энэ төвд хариуцуулна.

##### **Эрдэнэзууг сайжруулах**

Эрдэнэзуугийн орчин тойронг шинээр засварлан сэргээж тохилог, үзэмжтэй болгох

- ойр орчмын зам харгуйг сайжруулах
- автомашины зогсоол талбай байгуулах
- мэдээллийн самбаруудыг босгох
- Эрдэнэзуу дахь үзмэрүүдийг сайжруулах

#### 5) Холбогдох дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөгөө


##### **Замууд**

- Хархорин- Хар Балгас- Хөшөө Цайдам- Хархорин, Хархорин- Хужирт- Орхоны хүрхрээ чиглэлийн замуудыг хайрган зам болгон сайжруулах
- замын тэмдгүүдийг байрлуулах (замын хөдөлгөөний мэдээлэл, хурдны хязгаар, ан амьтнаас болгоомжлох тэмдэг г. м. )

##### **Орон нутгийн онгоцны буудал**


- Хархорины онгоцны буудлыг сайжруулах

Хархорин болон Хархорины аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх бодлого (2005 он хүртэлх)




МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
Я.ОНЧ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АГЕНТЛАГ (ОААЖА)
<b>МОНГОЛ УЛСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ</b>
Хүснэгт 4.3 Хархорин болон Хархорины аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх бодлого (2005 он хүртэлх)
ПАДЕКО Ко., Лтд. / Ниллон Коэй Ко., Лтд.

Хархорин болон Хархорины аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх бодлого (2005 он хүртэлх)



МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЯАНЫ СӨН УРСЫН ХАМТЫН АЖИЛГААНЫ АГЕНТЛАГ (ОАЖХА)
<b>МОНГОЛ УЛСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ</b>
Хүснэгт 4.3 Хархорин болон Хархорины аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх бодлого (2005 он хүртэлх)
ПАДЕКО Ко., Лтд / Ниппон Коэй Ко., Лтд

### Хархорин болон Хархорины аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх бодлого (2015 он хүртэлх болон түүнээс цааших)



**Жуулчид олноор очдог газарт хүрэх зам харуулж сайжруулах**

- 2015 он хүртэлх
  - Өгий нуур- Хар балгас (2015 он хүртэл шинэ)
  - Өгий нуур- Хөшөө Цайдам (2015 он хүртэл шинэ)
  - Өгий нуур - Цэцэрлэг (2015 он хүртэл сайжруулах)
  - Хархорин-Цэцэрлэг (2015 он хүртэл сайжруулах)
- 2015 оноос хойш
  - Орхон- Найман нуур (2015 оноос хойш шинэ)

**Аялал жуулчлалын цөм газруудыг хөгжүүлэх нь (Хужирт, Өгий нуурын орчинг 2015 он хүртэл, Найман нуурыг 2015 оноос хойш)**


- Орчныг тохижуулах
- Аялал жуулчлалын зам маршрут
- Жуулчдад зориулсан тэмдгүүд
- Автомашини зогсоолууд
- Ая тух хангах байгууламжууд

**Шинэ онгоцны буудлын барилга байгууламжуудыг барих**

- Хархорин (Шинэ онгоцны буудлын зурвас)
- Онгоц газардуулах төхөөрөмжийн систем
- Захиалгын систем
- Зочдын үйлчилгээний төхөөрөмж

МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЯОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АГЕНТЛАГ СКАРЖА
<b>МОНГОЛ УЛСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ</b>
Хүснэгт 4.4 Хархорин болон Хархорины аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх бодлого (2015 он хүртэлх болон түүнээс цааших)
ПАДЕКО Ко., Лтд / Нилсон Коой Ко., Лтд.

### Хархорин болон Хархорины аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх бодлого (2015 он хүртэлх болон түүнээс цааших)



**Жуулчид олноор очдог газарт хүрэх зам харгуйг сайжруулах**

- 2015 он хүртэлх
- Өгий нуур – Хар балгас (2015 он хүртэл шинэ)
  - Өгий нуур – Хөшөө Цайдам (2015 он хүртэл шинэ)
  - Өгий нуур – Цэцэрлэг (2015 он хүртэл сайжруулах)
  - Хархорин – Цэцэрлэг (2015 он хүртэл сайжруулах)
- 2015 оноос хойш
- Орхон – Найман нуур (2015 оноос хойш шинэ)

**Аялал жуулчлалын цөм газруудыг хөгжүүлэх нь (Хужирт, Өгий нуурын орчинг 2015 он хүртэл, Найман нуурыг 2015 оноос хойш)**

- Орчныг тохижуулах
- Аялал жуулчлалын зам маршрут
- Жуулчдад зориулсан тэмдгүүд
- Автомашин зогсоолууд
- Ая тух хангах байгууламжууд

**Шинэ онгоцны буудлын барилга байгууламжуудыг барих**

- Хархорин (Шинэ онгоцны буудлын зурвас)
- Онгоц газардуулах төхөөрөмжийн систем
- Захиалгын систем
- Зочдын үйлчилгээний төхөөрөмж

МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
Я.ОНЫ ОЛОН УЛСЫН ХАЛТЫН АЖИЛГААНЫ АГЕНТЛАГ (ЖААЖА)
<b>МОНГОЛ УЛСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ</b>
Хүснэгт 4.4 Хархорин болон Хархорины аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх бодлого (2015 он хүртэлх болон түүнээс цааших)
ПАДЕКО Ко., Лтд / Нилон Коэй Ко., Лтд.

### 4.3 Өмнөговийн бүс нутаг

#### 1) Хөгжлийн үндсэн бодлого, стратегиуд

##### Бүс нутгийн хөгжлийн ерөнхий зарчим

- Монголын байгалийн чиглэлийн аялал жуулчлалын өмнөд хэсгийн гол төв болох үүргийг хүчтэй болгох ( Японы жуулчдад говь үзүүлэх хамгийн тохиромжтой нутаг)
- Байгалийн чиглэлийн энгийн аялал жуулчлалыг голлон хөгжүүлэхэд анхаарах
- Өвөрмэц сонирхлын аялал жуулчлалыг сонирхогчдод зориулан бүс нутгийг хөгжүүлэх ( байгалийн гойд сонирхолтой жуулчлал, эко-жуулчлал, хялбар болон бартаат аялалууд, палеонтолог, агуйн судлал г.м.)

##### Хөгжлийн стратеги

- Аялал жуулчлалын гол газруудад үзэмжтэй танилцуулга, жуулчдын мэдээлэл бэлтгэж тавих, уг газруудын сэдвээр бэлэг дурсгалын зүйлс хийж худалдаалах (жишээлбэл, Ёлын Ам)
- Ёлын Аман дахь түүх байгалийн сэдэвт музейг сайжруулах
- Орон нутгийн байгальтай дэлгэрэнгүй танилцах тусгай программууд зохион байгуулах
- Хялбар аялал, идэвхтэй амралт, арга хэмжээг гол гол гэр баазуудын орчинд зохион байгуулах
- Холын чиглэлийн урт хугацааны аялал хийхэд зориулан Улаанбаатар, Хархорин, Өмнөговийг хооронд нь холбох үндсэн бааз, түшиц газар болгох үүргийг гүйцэтгүүлэх

#### 2) Аялал жуулчлалын эрэлт хэрэгцээний хэтийн төлөв

Өмнөговийн аялал жуулчлалын эрэлт хэрэгцээг дор дурдсанаар төлөвлөв.

	Бүгд (жуулчин– хоног)
1997	43318
2005	141000
2015	396000

#### Зочид буудлын эрэлт хэрэгцээ

2005 он: Оргил ачаалалын улиралд (7,8дугаар сард) одоогоос 2 дахин илүү хүчин чадлын хэрэгцээ гарна.



2015 он: Оргил ачаалалын улиралд (7,8дугаар сард) одоогоос 6 дахин илүү хүчин чадлын хэрэгцээ шаардагдах ба 5,6,9 дүгээр саруудад одоогийн байгаагаас бага зэрэг илүү хүч чадал хэрэгтэй.

### 3) Төлөвлөгөөний бүтэц, газар ашиглалт

Дээр дурдсан стратегийг хэрэгжүүлэхийн тулд 4.5, 4.6 хүснэгтэд үзүүлсэн 2005 он болон 2015 он хүртэлх хугацааны Өмнөговийн хөгжлийн төлөвлөгөөг санал болгож байна. Одоогийн байгаа аялал жуулчлалын баазуудыг (чиглэлүүд) аймгийн төв Даланзадгад хотын байрлаж буй нутгийн зүүн хэсгийн нөөц бололцоог өргөн ашиглах замаар сайжруулж шинэчлэх хэрэгтэй. Цаашид Говь Гурван Сайханы дархан цаазат газрын төв хэсэг болох Сэврээ, мөн Нарандаац, дархан цаазат газрын баруун хэсгийг жуулчлалын зориулалтаар хөгжүүлэх асуудлыг тусгав .

### 4) Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сайжруулах

#### Байгалийн музей ( байгаа музейг сэргээн засварлаж шинэчлэх)

Ёлын амны эхэнд байгаа Байгалийн музейг сэргээн засварлаж шинэчлэх шаардлагатай байна. Сэргээн засварлах ажлын үндсэн гол агуулга нь:

- Зочдыг хүлээн авах төв байгуулах ( мэдээллийн төв)
- Дээр дурдсан Зочдыг хүлээн авах төвд ажиллах хүч бэлтгэх
- Барилга байгууламж, орчин тойронг тохижуулан үзэмжтэй болгох
- Үзмэрүүдийг сайжруулах ( англи хэл дээр танилцуулга тайлбарыг бичиж хадах, динозаврын үзмэрүүдийг баяжуулах)

#### Жуулчны бааз

Улаанбаатар, Өмнөговь, Хархорины хоорондох тойрог аялалын түшиц баазыг байгуулахыг санал болгон дэвшүүлж байна. Уг жуулчны түшиц баазад 4 үндсэн чиглэлийн үйлчилгээний байгууллагууд байх ёстой. Үүнд:

- Автомашины үйлчилгээний газар: шатахуун түгээврийн газар, автомашины засварын газар, замын хөдөлгөөний мэдээлэл
- Хүнсний болон ундааны дэлгүүрүүд, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх цэг
- Мэдээллийн төв: Зочид буудал, зоогийн газар, малчдын гэрт зочлох талаар мэдээлэл
- Дамжлагын жижиг төв: тэмээ унах, агаарын спорт г.м.

#### Бусад арга хэмжээ

Баян Заг ( динозавр), Молцог Элс, Ёлын ам, Сэврээ, Нарандаац зэрэг жуулчдын очдог гол гол газруудад алжаал тайлах байгууламжийг (машины зогсоол, бие засах газар, амарч суух сандал) байгуулах шаардлагатай байна.

## 5) Холбогдох дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөгөө


### Замууд

- Даланзадгад Сэврээгийн хооронд энгийн хайрган зам барьж байгуулах
- Аялал жуулчлалын гол газруудад хүрэх замуудын дагуу замын тэмдгүүдийг байршуулах

### Орон нутгийн онгоцны буудлууд

- Жуулчны гэр баазуудын орчмын онгоцны буудлыг сайжруулах
- Өмнөговийн зүүн хэсэгт (Сэврээ, Нарандаац) шинэ жижиг онгоцны буудлуудыг байгуулах

Өмнөговийн аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх бодлого (2005 он хүртэл)



Аялал жуулчлалын цөм газруудыг хөгжүүлэх нь (Елын ам, Баянзаг, Даланзадгад)

- Зочдыг хүлээн авах төв
- Аялал жуулчлалын зам маршрут
- Жуулчдад зориулсан тэмдгүүд
- Автомашинь зогсоолууд
- Ая тух хангах байгууламжууд


Даланзадгад дахь байгаль хамгаалагчдын сургалт

Тал дахь онгоцны буудлын зурвасыг өргөтгөх

- Онгоцны буудлын зурвасыг сайжруулах
- Онгоц газардуулах төхөөрөмжийн систем
- Захиалгын систем
- Зочдын үйлчилгээний төхөөрөмж

МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
Я.ОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АГЕНТЛАГ (ЖАЙЖА)
<b>МОНГОЛ УЛСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ</b>
Хүснэгт 4.5 Өмнөговийн аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх бодлого (2005 он хүртэл)
ПАДЕКО Ко., Лтд. / Ниппон Косэй Ко., Лтд.

Өмнөговийн аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх бодлого (2005 он хүртэл)



Аялал жуулчлалын цөм газруудыг хөгжүүлэх нь (Ельн ам, Баянзаг, Даланзадгад)

- Зочдыг хүлээн авах төв
- Аялал жуулчлалын зам маршрут
- Жуулчдад зориулсан тэмдгүүд
- Автомашинны зогсоолууд
- Ая тух хангах байгууламжууд


Тал дахь онгоцны буудлын зураасыг өргөтгөх

- ▬ Онгоцны буудлын зураасыг сайжруулах
- ▬ Онгоц газардуулах төхөөрөмжийн систем
- Захиалгын систем
- Зочдын үйлчилгээний төхөөрөмж

Даланзадгад дахь байгаль хамгаалагчдын сургалт

МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЯОНЫ ОЙГОЙ УЛСЫН ХАМТЫН АЖИЛГААНЫ АГЕНТЛАГ (ЖАХАА)
<b>МОНГОЛ УЛСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ</b>
Хүснэгт 4.5 Өмнөговийн аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх бодлого (2005 он хүртэл)
ПАДЕКО Ко., Лтд. / Нилтон Коэй Ко., Лтд.

Өмнөговийн аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх бодлого  
(2015 он хүртэлх болон цаашдын)



Жуулчид олноор очдог газарт хүрэх зам харгуйг сайжруулах

■ Даланзадгад – Сээрээ

Аялал жуулчлалын 2 дугаар зэргийн цөм газруудыг хөгжүүлэх (Сээрээ, Нарандаацын бүс нутаг)

- Зочдыг хүлээн авах төв
- Аялал жуулчлалын зам маршрут
- Жуулчдад зориулсан тэмдгүүд
- Автомашинь зогсоолууд
- Ая тух хангах байгууламжууд

Нарандаацад шинэ тусгай онгоцны буудал барих (2015 он хүртэл)

- Онгоцны буудлын шинэ зурвас
- Онгоц газардуулах төхөөрөмжийн систем
- Захиалгын систем
- Зочдын үйлчилгээний төхөөрөмж

● Даланзадгадын аялал жуулчлалын бааз


МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ  
Я.ОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛАГААНЫ АГЕНТЛАГ ОРГАНЫ

**МОНГОЛ УЛСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 4.6  
Өмнөговийн аялал жуулчлалын бүс  
нутгийг хөгжүүлэх бодлого  
(2015 он хүртэлх болон цаашдын)

ПАДЕКО Ко., Лтд. / Нилсон Коэй Ко., Лтд.

### Өмнөговийн аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх бодлого (2015 он хүртэлх болон цаашдын)



Жуулчид олноор очдог газарт хүрэх зам харгуйг сайжруулах

◀---> ■ Даланзадгад-Сэврээ

Аялал жуулчлалын 2 дугаар зэргийн цөм газруудыг хөгжүүлэх (Сэврээ, Нарандаацын бүс нутаг)

- Зочдыг хүлээн авах төв
- Аялал жуулчлалын зам маршрут
- Жуулчдад зориулсан тэмдгүүд
- Автомашинь зогсоолууд
- Ая тух хангах байгууламжууд

Нарандаацад шинэ тусгай онгоцны буудал барих (2015 он хүртэл)

- Онгоцны буудлын шинэ зурвас
- Онгоц газардуулах төхөөрөмжийн систем
- Захиалгын систем
- Зочдын үйлчилгээний төхөөрөмж

📍 Даланзадгадын аялал жуулчлалын бааз

МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ  
Я.ОИЛЧ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖЛАГААНЫ АГЕНТЛАГ (ХААХА)  
**МОНГОЛ УЛСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 4.6  
Өмнөговийн аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх бодлого  
(2015 он хүртэлх болон цаашдын)

ГАДЕКО Ко., Лтд. / Нилпон Коэй Ко., Лтд.